



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 11 дүгээр
сарын 3-ны өдөр

Дугаар 120


Улаанбаатар
хот

Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх
төлөвлөгөө батлах тухай

“Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Улсын Их Хурлын 2012 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 37 дугаар тогтоолын 2.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хавсралт ёсоор баталсугай.

2. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хугацаанд нь шуурхай хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллан, хэрэгжилтийн явцад жил бүрийн 6, 12 дугаар сарын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга

Н.АЛТАНХУЯГ

Ч.САЙХАНБИЛЭГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2012-2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт	Арга хэмжээний дугаар	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага			Хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая төгрөг/	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
					Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Бусад оролцогч байгууллага		
НЭГ. АЖИЛТАЙ, ОРЛОГОТОЙ МОНГОЛ ХҮН									
1.	Бизнесийг дэмжсэн татварын хоёр дахь үе шатны шинэчлэлийг хийх	1	Татварын шинэчлэлийн хүрээнд Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Жижиг хэмжээний ажил, үйлчилгээ эрхлэгч этгээдийн орлогын албан татварын тухай, Өв залгамжлал, бэлэглэлийн албан татварын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна	2012-2014	СЯ				Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
		2	Уул уурхай, ашигт малтмал, нефтийн бүтээгдэхүүний импорт, газрын тосны экспорт, үүрэн холбооны операторын үйлчилгээ, архи, спирт, тамхи үйлдвэрлэх зэргээс бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн борлуулалтын орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс илүүгүй аж ахуйн нэгжийн төсөвт төлсөн орлогын албан татварын 90 хувийг буцаан олгох чиглэлээр Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Жижиг, дунд үйлдвэрийн тухай, Хоршооны тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулна.	2013	ЭЗХЯ	ҮХААЯ СЯ БХБЯ			Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.

		3	Биеийн тамир, спорт, соёл, урлагийн салбарт оруулсан хөрөнгө оруулалт болон ивээн тэтгэсэн хөрөнгийг татвараас хөнгөлөх, чөлөөлөх, урамшуулах эрх зүйн орчин бүрдүүлнэ.	2012-2016	СЯ	ССАЖЯ			Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
		4	Шинээр ашиглалтад орсон жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний газар, хөдөө аж ахуйн хоршоодыг 1-1.5 жил хүртэл хугацаанд аж ахуйн нэгжийн орлогын болон Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлж хөнгөлөлт үзүүлэх асуудлыг судалж шийдвэрлэнэ.	2013-2014	СЯ	ҮХААЯ ЭЗХЯ			Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
		5	Газрын тос боловсруулах, зэс хайлах, ган үйлдвэрлэх, төмөр зам барих, машины үйлдвэр зэрэг стратегийн ач холбогдол бүхий томоохон үйлдвэр, байгууламжийг барих зорилгоор импортоор оруулж ирсэн тоног төхөөрөмжид ногдох гаалийн албан татварыг хөнгөлөх асуудлыг судалж шийдвэрлэнэ.	2013-2014	СЯ	ЭЗХЯ ҮХААЯ ЗТЯ			Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
		6	Гадаад улстай байгуулсан давхар татварын гэрээг Монгол Улсын эрх ашигт нийцүүлэн шинэчлэх, эсхүл хүчингүй болгоно.	2013-2015	ЭЗХЯ	ХЗЯ			Гэрээнүүдийг шинэчилж, хүчингүй болгосон байна.
2.	Зээлийн хүүг бууруулж нэг оронтой тоонд оруулах	1	Зээлийн хүү бууруулах хөтөлбөр хэрэгжүүлэн, нэг оронтой тоонд оруулна.	2013-2015	Монголбанк	ЭЗХЯ СЯ ҮХААЯ БХБЯ		10.0	Зээлийн хүүг бууруулж нэг оронтой тоонд оруулсан байна.
		2	Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан "Зээлийн хүү буурах зах зээлийн орчныг бүрдүүлэх хөтөлбөр"-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	2012-2016	Монголбанк	СЯ ЭЗХЯ ЗХ	МБХ		Зээлийн хүү буурах зах зээлийн орчин бүрдсэн байна.
		3	"Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэл"-ийн хүрээнд банкны эрсдэлийг бууруулах, улмаар зээлийн хүү буурах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор барьцаа хөрөнгийн эрх зүйн орчныг шинэчлэнэ.	2013-2014	Монголбанк		МБХ		Эрх зүйн орчныг шинэчилсэн байна.
3.	Орон сууцны зээлийн тогтолцоог шинэчлэх	1	Орон сууцны санхүүжилтийн нэгдсэн стратеги боловсруулан хэрэгжүүлнэ.	2012-2013	БХБЯ	ЭЗХЯ СЯ Монголбанк	АНЗД		Нэгдсэн стратегитай болно.
		2	Орон сууцны санхүүжилтийн асуудлыг зохицуулсан хуулийн төсөл боловсруулна.	2012-2014	БХБЯ	ЭЗХЯ СЯ ХЗЯ Монголбанк	АНЗД		Хууль эрх зүйн орчин бүрдсэн байна.
		3	Орон сууцны эрэлт, нийлүүлэлтийн нэгдсэн судалгаа хийж, мэдээллийн сан байгуулан ажиллуулна.	2013-2016	БХБЯ	ЭЗХЯ ҮСХ	АНЗД	3.000.0 Улсын төсөв	Мэдээллийн нэгдсэн сантай болсон байна.

		4	Орон сууц хөнгөлөлттэй үнээр борлуулах журам боловсруулж, Орон сууцны зээлийн баталгааны сан байгуулна.	2012-2013	БХБЯ	ЭЗХЯ СЯ Монголбанк	АНЗД	10.000.0 Улсын төсөв АХБ	Иргэд орон сууц хөнгөлөлттэй үнээр худалдан авах нөхцөл бүрдэж, зээлийн баталгааны сантай болсон байна.
		5	Эрчим хүчний хэмнэлттэй орон сууцыг дэмжих сан байгуулж, санхүүгийн механизмыг бүрдүүлнэ.	2013-2016	БХБЯ	ЭЗХЯ СЯ Монголбанк	АНЗД	10.000.0 Улсын төсөв	Орон сууцыг дэмжих сан байгуулагдсан байна.
		6	“Төрийн албан хаагчдын орон сууц” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж дуусгана.	2012-2015	БХБЯ	Төрийн байгууллага	ХХ		Хөтөлбөр хэрэгжиж дууссан байна.
		7	Түрээсийн 1000 айлын орон сууцыг барьж ашиглалтад оруулна.	2012-2016	БХБЯ		НЗД ХХ	57.600.0 Улсын төсөв	1000 айлын орон сууцыг ашиглалтад оруулсан байна.
4.	Ажлын байр шинээр бий болгох хөтөлбөр хэрэгжүүлэх	1	Ажлын байр шинээр бий болгох хөтөлбөр батлан хэрэгжүүлнэ.	2012-2016	ХЯ				Хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.
5.	Инфляцид хөтлөгдөх бус зохицуулдаг тогтолцоонд шилжих	1	Газрын тосны бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах зорилтын хүрээнд бусад орны сайн туршлагыг импортлогч компаниудтай хамтран судалж, компаниудад боломжит дэмжлэг үзүүлнэ.	2012	ЭЗХЯ	УУЯ			Компаниудад дэмжлэг үзүүлсэн байна.
		2	Газрын тосны бүтээгдэхүүний үндэсний үйлдвэр байгуулна.	2013	ЭЗХЯ	УУЯ			Үйлдвэр баригдсан байна.
		3	Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн импортлох урт хугацааны худалдааны гэрээг ОХУ болон холбогдох бусад улстай байгуулна.	2013	ЭЗХЯ	УУЯ			Гэрээнүүдийг байгуулсан байна.
		4	Газрын тосны бүтээгдэхүүн импортлогч компаниудтай хамтран 60-90 хоногийн нөөц бүрдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	2012-2016	УУЯ				Газрын тосны 60-90 хоногийн нөөцтэй болсон байна.
		5	Импортоор оруулж байгаа хүнсний болон бусад бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх чиглэлээр төсөл боловсруулж хэрэгжүүлнэ.	2013-2015	ЭЗХЯ	ҮХААЯ БХБЯ			Хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн байна.
		6	Дотоодын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр үйлдвэрлэлийг дэмжих төсөл боловсруулж хэрэгжүүлнэ.	2013-2015	ЭЗХЯ	ҮХААЯ			Хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн байна.
		7	Барилгын материалын импортыг бууруулж эх орондоо үйлдвэрлэдэг болох арга хэмжээ авна.	2013-2015	ЭЗХЯ	БХБЯ			Дотоодын үйлдвэрлэл өссөн байна.

		8	Инфляцийг төсөөлөх, бодлогын шинжилгээ хийх загваруудыг хөгжүүлж, сайжруулна.	2012-2015	ЭЗХЯ		Монголбанк		Инфляци буурсан байна.
		9	Мөнгөний нийлүүлэлтээс шууд хамааралтай инфляци өсөхөөс бусад тохиолдолд Төв банкны хүүг бууруулах механизмыг хэрэгжүүлнэ.	2013-2015	ЭЗХЯ		Монголбанк		
		10	Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн одоогийн тогтолцоог зохицуулалттай ханшийн тогтолцоонд шилжүүлнэ.	2013	ЭЗХЯ		Монголбанк		
		11	Урт хугацаатай, хүү багатай зээлийн бодлогоор бодит эдийн засгийг дэмжих механизмыг арилжааны банкуудад бий болгох бодлого явуулна.	2012-2015	ЭЗХЯ		Монголбанк		
		12	Улаанбаатар-Замын-Үүдийн авто замыг тэргүүн ээлжинд ашиглалтад оруулж, Замын-Үүдийн хилийн боомтын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлснээр инфляцийн зохиомол хөөрөгдлийг бууруулна.	2012-2013	ЭЗХЯ			Зам ашиглалтад орсон байна.	
		13	Дотоодын үйлдвэрлэгчдийн хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд, бүтээгдэхүүнийг биржээр борлуулах нөхцөлийг бүрдүүлж, бүтээгдэхүүний үнийн зохиомол өсөлтийг хязгаарлана.	2012-2013	ЭЗХЯ	ҮХААЯ		Бүтээгдэхүүнүүдийг биржээр худалдаалдаг болсон байна.	
		14	Түлш, шатахуун, цахилгаан эрчим хүч зэрэг бусад бараа, бүтээгдэхүүний үнэд шууд нөлөөлдөг суурь бүтээгдэхүүний үнийг төрөөс зохицуулдаг болгох бодлого явуулна.	2012-2013	ЭЗХЯ			Зохицуулалт бий болсон байна.	
		15	Зарим бараа бүтээгдэхүүний үнэ тарифын зохицуулалтын талаар хуулийн төсөл боловсруулна.	2013	ЭЗХЯ			Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.	
		16	Арилжааны банкуудын заавал байлгах нөөцийн зохих хэсгийг эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн бонд худалдан авах чиглэлээр ашиглах асуудлыг судалж хэрэгжүүлнэ.	2013	ЭЗХЯ			Бонд худалдан авах эрх зүйн орчин бүрдсэн байна.	
6.	Барилгын материалыг эх орондоо үйлдвэрлэдэг болох	1	Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр батлан хэрэгжүүлнэ.	2012-2016	БХБЯ	ҮХААЯ	ТББ ХХ		Хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн байна.
		2	Барилгын материалын нэр төрөл, эрэлт, нийлүүлэлтийн судалгааг гарган мэдээллийн сан байгуулна.	2013-2014	БХБЯ	ҮХААЯ БШУЯ	ТББ ХХ	1.200.0 Улсын төсөв	Мэдээллийн сантай болсон байна.
		3	Барилгын түгээмэл тархацтай ашигт малтмалын үнийг болон тэдгээрийг ашиглах хураамж, төлбөрийн хэмжээг зохистой түвшинд тогтооно.	2013-2016	БХБЯ	УУЯ	НЗД ТББ ХХ		Хураамж, төлбөрийн түвшинг тогтоосон байна.

7.	Экспортын нэг цонхны бодлого хэрэгжүүлэх	1	Эрдэс түүхий эдийн биржийн эрх зүйн орчныг бүрдүүлж хэрэгжүүлнэ.	2012-2013	ЭЗХЯ	ХЗЯ УУЯ			Эрх зүйн орчин бүрдсэн байна.
		2	Олон улсын зах зээлд Монгол Улсын брэнд бүтээгдэхүүн бий болгоно.	2012-2015	ЭЗХЯ	ҮХААЯ			Брэнд бүтээгдэхүүн бий болсон байна.
		3	“Оюуны өмчийн хөгжлийн сан” байгуулж, эдийн засгийн үр ашигтай оюуны өмчийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, гадаад орнуудад хамгаалахад дэмжлэг үзүүлнэ.	2014-2016	ОӨГ				Санг байгуулж, эдийн засгийн үр ашигтай оюуны өмчийг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байна.
		4	Газар зүйн заалтын зохицуулалтаар дамжуулан үндэсний болон орон нутгийн брэнд болсон бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг экспортод гаргах эрх зүй, зохицуулалтын боломжийг бүрдүүлнэ.	2013-2016	ОӨГ				Үндэсний болон орон нутгийн брэнд бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг экспортод гаргах боломжтой болсон байна.
8.	Хилийн боомтын шинэчлэлийг хийх	1	Замын-Үүд, Алтанбулаг, Ханги, Бичигт, Бургастай, Булган, Ханх, Зэлтэр боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулна.	2013-2014	БХБЯ	СЯ ХЗЯ ЭЗХЯ	Холбогдох АЗД	2.600.0 Улсын төсөв	Ерөнхий төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлж эхэлсэн байна.
		2	Замын-Үүд, Алтанбулаг, Гашуунсүхайд, Шивээхүрэн, Боршоо, Бичигт, Ханги, Бургастай, Булган, Ханх, Зэлтэр боомтуудын батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг үе шаттай боловсруулна.	2012-2015	БХБЯ	СЯ ЭЗХЯ ХЗЯ	Холбогдох АЗД	3.400.0 Улсын төсөв	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлсэн байна.
		3	Хилийн боомт дээр ажиллаж байгаа хилийн хяналтын байгууллагуудын зохион байгуулалтыг шинэчилнэ.	2013-2014	ЗГХЭГ	ЭЗХЯ СЯ ХЗЯ МХЕГ			Хилийн хяналтын байгууллагуудын удирдлага зохион байгуулалт шинэчлэгдсэн байна.
		4	Улс, бүс нутгийн болон аймгийн онцгой ач холбогдол бүхий боомтуудын шинэчлэлийг хийж, үндсэн дэд бүтцийг цогцоор нь барьж байгуулна.	2013-2015	ЭЗХЯ	БХБЯ ЭХЯ ХЗЯ		Улсын төсөв Гадаадын зээл тусламж	Хилийн боомтуудын дэд бүтэц бий болсон байна.
		5	Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонхны систем, тээвэр ложистикийг хэрэгжүүлэхэд олон улсын хууль эрх зүйн хүрээнд хөрш орнуудтай хэлэлцэн тохиролцох зарчмаар шийдвэрлэнэ.	2012-2015	ЭЗХЯ	ГХЯ Холбогдох яам Агентлаг		Улсын төсөв	Гадаад худалдааг хөнгөвчлөх нэг цонхны систем, тээвэр ложистик бий болсон байна.

9.	Хөрөнгийн биржийг шинэчлэх	1	Хөрөнгийн биржийн дэд бүтцийг бүрдүүлж, гадаадын ижил төрлийн байгууллагуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, арилжаа явуулах нөхцөлийг бүрдүүлж хэрэгжүүлнэ.	2013-2014	ЭЗХЯ		МХБ		Хамтын ажиллагааг эхлүүлсэн байна.
		2	Хөрөнгийн бирж болон брокер, дилер компаниудын чадавхийг сайжруулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	2013-2015	ЭЗХЯ	СЗХ СЯ	МХБ		Хөтөлбөр хэрэгжсэн байна.
10.	Банк санхүү, бирж, мэдээллийн технологи, амралт цэнгээний болон агаарын замын зангилаа төв байгуулах ажлыг эхлүүлэх	1	Ази, Европ, Америк тивийг холбосон агаарын замын оновчтой огтлолцол дээр тусгай хуулийн зохицуулалттай банк, санхүү, бирж, мэдээллийн технологи, амралт цэнгээний болон агаарын замын зангилаа төв байгуулах, хэрэгжүүлэх асуудлыг судалж зохицуулах үүрэг бүхий төслийн баг ажиллуулна.	2013-2014	ЭЗХЯ	ЗТЯ БХБЯ ЭХЯ ССАЖЯ МТШХХГ СЗХ			Төслийн баримт бичиг бэлэн болсон байна.
		2	Зангилаа төвийн үйл ажиллагааг зохицуулах тусгайлсан хуулийн төсөл боловсруулна.	2013-2014	ЭЗХЯ	ХЗЯ		Улсын төсөв Гадаадын зээл, тусламж Концесс	Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
		3	Гадаадын томоохон банк, санхүүгийн байгууллагын салбар байгуулах, гадаадын иргэд зорчих болон гадаадын хөрөнгө оруулагчдыг татах чиглэлээр хууль эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ.	2013-2014	ЭЗХЯ	ХЗЯ СЗХ ЗТЯ БХБЯ ЭХЯ ССАЖЯ			Эрх зүйн орчин бүрдсэн байна.
		4	Зангилаа төвийн байршлыг оновчтой сонгох, техник, эдийн засгийн үндэслэл, ерөнхий төлөвлөгөө, зураг төсөл боловсруулах, төвийн дэд бүтэц, барилгажилтын ажлыг эхлүүлэх арга хэмжээ авна.	2014-2016	ЭЗХЯ	ЗТЯ БХБЯ ЭХЯ ССАЖЯ			Барилгажилтын ажлыг эхлүүлсэн байна.
		5	Зангилаа төвийн бүхий л үйл ажиллагаанд мэдээллийн технологийн орчин үеийн техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж ашиглана.	2012-2015	ЭЗХЯ	МТШХХГ		Улсын төсөв Хувийн болон гадаадын хөрөнгө оруулалт	Мэдээллийн технологийн техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн байна.
11.	Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн төслийн зарлагыг өсгөхгүй, алдагдлыг нэмэгдүүлэхгүй байх зарчмыг хуульчлах	1	Төсвийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад нийцүүлэн төсвийн зарлагыг өсгөхгүй байх, алдагдлыг нэмэгдүүлэхгүй байхаар боловсруулан УИХ-д өргөн мэдүүлж байна.	2012-2016	СЯ				Шаардлага хангасан төсвийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
12.	Инфляцийг нэг оронтой тоонд барьж, төгрөгийн худалдан авах чадварыг тогтвортой байлгах;	1	Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн хүрээнд	2012-2016	Монголбанк	ЭЗХЯ СЯ			Хэрэглээний үнийн индексээр

			мөнгөний бодлогын арга хэрэгслээр инфляцийг нам түвшинд тогтвортой байлгаж, нийлүүлэлтийн гаралтай инфляцийн нөлөөллийг хязгаарлах бодлого баримтална.						хэмжигдэх инфляцийг 2013 онд 8 хувиас хэтрүүлэхгүй, 2014-2015 онд 5-7 хувийн түвшинд байлгасан байна.
		2	“Зээлийн хүү буурах зах зээлийн орчныг бүрдүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд Төрийн мөнгөний болон төсвийн бодлогыг уялдаатай, мөчлөг сөрсөн байдлаар явуулж, инфляцийг нам түвшинд тогтвортой байлгах макро нөхцөлийг бүрдүүлнэ.	2012-2014	Монголбанк	ЭЗХЯ СЯ			
13.	Улсын төсвийн зардлыг хязгаарлаж, дотоодын нийт бүтээгдэхүүнд төсвийн эзлэх хувийг 40-өөс илүүгүй байлгах	1	Улсын төсвийн зардлыг хязгаарлаж, дотоодын нийт бүтээгдэхүүнд төсвийн эзлэх хувийг 40-өөс илүүгүй байлгах талаар дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгаж хэрэгжүүлнэ.	2012-2016	СЯ				Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан байна.
		2	Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, зарлагын хязгаар, төсвийн төсөл, тодотголын төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай, Төсвийн тухай хуулийг баримтлан боловсруулж төсвийн зарлагын өсөлт, ДНБ-д эзлэх хувийг хязгаарлана.	2012-2016	СЯ				Шаардлага хангасан төсвийн төслийг батлуулсан байна.
		3	Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн төсвийн төслийг батлахдаа зарлагыг өсгөхгүй, алдагдлыг нэмэгдүүлэхгүй байх зарчмыг холбогдох хуульд нэмж тусган, мөрдүүлнэ.	2013	ЭЗХЯ	СЯ			Хуульд нэмэлт орсон байна.
14.	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн алдагдлыг хоёр хувиас илүүгүй байлгах;	1	Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, зарлагын хязгаар, төсвийн төсөл, тодотголын төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагын дагуу нэгдсэн төсвийн алдагдлыг ДНБ-ий -2.0 хувьтай тэнцүү байхаар боловсруулж УИХ-д өргөн мэдүүлж байна.	2012-2016	СЯ				Шаардлага хангасан төсвийн төслийг батлуулсан байна.
15.	Хөрөнгө оруулалтыг тав хүртэл жилээр төлөвлөх зарчимд шилжих	1	Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх барилга байгууламж, объектыг зориулалт, хүчин чадал, байршлаар нь заасан хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулж батална.	2012	ЭЗХЯ				Хөтөлбөр батлагдсан байна.
		2	Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх барилга байгууламж, объектыг улс, салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн оролцоотой хэлэлцүүлэг явуулсны үндсэн дээр тогтоож байх нөхцөл бүрдүүлнэ.	2012-2013	ЭЗХЯ	Яам агентлаг			Төлөвлөлт сайжирсан байна.

		3	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хөгжлийн бодлого төлөвлөлт, санхүүгийн эх үүсвэр, материал хангамж, ажиллах хүчний хүчин чадал зэрэг үзүүлэлттэй уялдуулан жил бүр тодотгож байна.	2012-2016	ЭЗХЯ	СЯ			Тодотголыг жил бүр хийж хэрэгжүүлсэн байна.
		4	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх үе шат бүрт гүйцэтгэх ажилбаруудын норм, норматив, стандартыг нарийвчлан тогтооно.	2012-2013	ЭЗХЯ	СХЗГ			Норм, норматив, стандартыг тогтоон мөрдүүлсэн байна.
		5	Барилга байгууламж, объектыг зориулалт, байршил, хүчин чадлаар нь эрэмблэн, нэг маягийн зураг төсөл баталсны үндсэн дээр төсөв зохиож, шинэ техник, технологи нэвтрүүлэх, инженерийн шийдэл гаргах, турших, үнэ бүрдэх механизмыг боловсронгуй болгох, тухайн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээ, хугацааг бодитой болгохтой холбогдсон зохицуулалтын цогц арга хэмжээ авч ажиллана.	2012-2013	ЭЗХЯ	СЯ			Зохицуулалтын механизм бүрдсэн байна.
16.	Алдагдалтай ажиллаж байгаа төрийн өмчийн компанийн удирдлагад хариуцлага тооцож, ашигтай ажиллахаар өөрчлөн зохион байгуулах	1	Алдагдалтай ажиллаж байгаа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийг өөрчлөн зохион байгуулж, ашигтай ажиллуулна.	2012-2016	ҮХААЯ				ТӨК-иуд ашигтай ажилласан байна.
		2	Алдагдалтай ажиллаж байгаа компаниудын удирдлагуудад хугацаатай үүрэг, даалгавар өгч, биелэлтийг хангуулж ажиллана.	2012-2016	ҮХААЯ				Шалгалтыг хийж, мөрөөр нь арга хэмжээ авсан байна.
17.	Тендерийн будлиан, авлига, хээл хахуулийг халах зорилгоор төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг 100 хувь онлайн хэлбэрт шилжүүлж, иргэд, олон нийтийн хяналт дор ил тод явуулж, захиалагч нь шийдвэрлэдэг өнөөгийн тендерийн тогтолцоог өөрчилж гүйцэтгэгч нь шийдвэрлэдэг болгох	1	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламж, объектыг чанартай гүйцэтгүүлэх зорилгоор Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа компанийн дотроос дадлага туршлагатай, нэр хүнд бүхий аж ахуйн нэгжүүдийн чансааг тодорхой шалгуур үзүүлэлтээр олон нийтийн хяналт дор жил бүр тогтоон мэдээлж байна.	2012-2016	СЯ	ХААГ	ИНБ		Чансааг тогтоон нийтэд мэдээлж хэвшсэн байна.
		2	Зураг төсөл, төсөв нь батлагдсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгохдоо чансаа нь тогтоогдсон компаниудаас захиалагч өөрөө сонгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	2012-2013	СЯ	ХААГ	ИНБ		Эрх зүйн орчин бүрдсэн байна.
		3	Цахим худалдан авах ажиллагааны систем (e-Shopping Mall) -ийг ашиглалтад оруулна.	2013-2016	СЯ	ХААГ	ИНБ		Системийг ашиглалтад оруулсан байна.
		4	Цахим тендер шалгаруулалтыг явуулж олон нийтэд сурталчлан таниулна.	2013-2016	СЯ	ХААГ	ИНБ		Олон нийтэд ил тод болсон байна.

18.	Гадаадын зах зээлээс хямд эх үүсвэрийг боломжит хэмжээгээр татаж зөвхөн бүтээн байгуулалтын төслүүдийг санхүүжүүлэх	1	Засгийн газраас хөгжлийн бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулан 5.0 хүртэлх тэрбум ам. долларын үнэт цаасыг олон улсын хөрөнгийн зах зээл дээр арилжиж, эх үүсвэрийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна.	2013-2016	ЭЗХЯ				Бонд гаргаж, эх үүсвэр татан хөрөнгө оруулалт хийгдсэн байна.
19.	Цалин, тэтгэврийн хэмжээг инфляцийн түвшин, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан нэмэгдүүлэх	1	Цалин хөлсний талаар үндэсний хэмжээнд баримтлах бодлогыг батлуулан, салбарын болон аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд ажиллагчдын ур чадвар, хөдөлмөрийн бүтээмжид суурилсан цалин хөлсний тогтолцоо бүрдүүлнэ.	2013	ХЯ	ЭЗХЯ СЯ		Улсын төсөв	Эрх зүйн орчин, тогтолцоо бүрдсэн байна.
		2	Үндэсний хэмжээнд “Хөдөлмөрийн бүтээмжийн хөдөлгөөн” өрнүүлж, цалин хөлс, хөдөлмөрийн бүтээмжийн уялдааг боловсронгуй болгоно	2012-2013	ХЯ	СЯ ХАХНХЯ	АНЗД МАОЭНХ МҮЭХ	200.0 ХЭДС	Хөдөлгөөнийг өрнүүлсэн байна.
		3	Тэтгэврийн хэмжээг инфляцийн түвшин, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан нэмэгдүүлнэ.	2013-2016	ХАХНХЯ	СЯ		324.900.0 Улсын төсөв	Дундаж тэтгэвэр 300.000, Халамжийн тэтгэвэр 140.000 төгрөгт хүрсэн байна.
20.	Цалин, тэтгэврийн хэмжээг өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийг өсгөхгүйн тулд нийтэд зарлахгүйгээр салбар бүрээр нэмэх	1	Цалингийн хэмжээг амьжиргааны түвшний өөрчлөлт буюу инфляцийн түвшинтэй уялдуулан индексжүүлэн нэмэгдүүлэх эрх зүйн орчин бүрдүүлнэ.	2013	ХЯ	СЯ ЭЗХЯ		Жилд дунджаар 100.200.0 Улсын төсөв	Эрх зүйн орчин бүрдсэн байна.
		2	Хувийн хэвшилд ажиллагчдын цалин салбарын цалин хөлсний тарифын хэлэлцээрээр нэмэгдүүлэх тогтолцоог бүрдүүлнэ.	2012-2013	ХЯ	ЭЗХЯ	МАОЭНХ МҮЭХ		Тогтолцоо бүрдсэн байна.
		3	Салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тухайн салбарын ажил олгогч, ажилтны төлөөлөлтэй хамтран тогтоож мөрдүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	2013	ХЯ	ЭЗХЯ	МАОЭНХ МҮЭХ		Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэн байна.
21.	Мөнгөний бодлогыг бодит эдийн засгийг дэмжихэд чиглүүлэх	1	Эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурь нөхцөл болсон макро эдийн засгийн болон санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэхэд мөнгөний бодлогыг чиглүүлнэ.	2012-2016	Монголбанк	ЭЗХЯ			Үндсэн чиглэл хэрэгжсэн байна.
22.	Түлш, шатахуун, цахилгаан эрчим хүч зэрэг бусад бараа, бүтээгдэхүүний үнэд нөлөөлдөг суурь бүтээгдэхүүний үнийг төрөөс зохицуулдаг болгох бодлого явуулах	1	Суурь үнэд голлон нөлөөлдөг гол нэрийн бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах талаар төрөлжсөн хөтөлбөр хамтран хэрэгжүүлнэ.	2012-2016	ЭЗХЯ	ҮХААЯ Монголбанк	ТББ	Улсын төсөв	Хууль хэрэгжсэн байна.
		2	Өрсөлдөөний тухай хуулийн 13.3-т заасан зохицуулалтад хамаарах бараа, бүтээгдэхүүний жагсаалт, хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагыг Засгийн газраас тогтоож, хэрэгжилтийг хангуулна.	2013-2016	ШӨХТГ	ЭХЯ Холбогдох яам агентлаг			

23.	Дэд бүтэц, боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Хөгжлийн банкаас олгох хөнгөлөлттэй зээлийн хэмжээг нэмэгдүүлэх	1	Боловсруулах үйлдвэр, цогцолбор шинээр барьж байгуулах, техник, технологийн шинэчлэл хийх, өргөтгөхөд зориулж Хөгжлийн банкаас зээл олгоно.	2012-2013	ҮХААЯ	ЭЗХЯ СЯ ХЗДХЯ		ХБ	Олгосон зээлийн хэмжээ нэмэгдсэн байна.
24.	Төсөв, санхүү, боловсон хүчний томилгоотой холбоотой орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлж, төвлөрлийг сааруулах	1	Салбарын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх агентлагуудын удирдлагыг аймаг, нийслэлийн Засаг дарга томилохдоо Засгийн газрын гишүүд, төрийн захиргааны байгууллагын удирдлагатай зөвшилцдөг тогтолцоонд шилжүүлнэ.	2013	ЗГХЭГ	ХЗЯ	АНЗД		Тогтолцоо бүрдсэн байна.
		2	Төсвийн тухай шинэ хуулийг хэрэгжүүлж, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан байгуулах, түүнээс сум, дүүргийн хөгжлийн санд хуваарилах итгэлцүүрийг тогтоож мөрдүүлнэ.	2012-2016	СЯ	ЗГХЭГ	АНЗД		Итгэлцүүрийг мөрдүүлсэн байна.
		3	Аймаг, нийслэлийн Засаг даргын Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулах гэрээнд орон нутгийн төсвийн байгууллагын урсгал зардлыг зарцуулах эрх олгох, хөрөнгө оруулалтын эрх мэдлийг нэмэгдүүлэх асуудлыг тусгаж хэрэгжүүлнэ.	2012-2016	ЗГХЭГ	Яам	АНЗД		Орон нутгийн байгууллага асуудлаа өөрсдөө шийдвэрлэдэг болсон байна.
		4	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан, тусгай зориулалтын шилжүүлэг, орлогын шилжүүлэг, орон нутгийн суурь төсвийг тооцох, санхүүгийн дэмжлэгийг олгох замаар орон нутгийн төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.	2013-2016	СЯ				Орон нутгийн төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлсэн байна.
25.	Бусад улстай хийсэн давхар татварын гэрээг Монгол Улсын эрх ашигт нийцүүлэн шинэчлэх, эсхүл хүчингүй болгох	1	Монгол Улсаас бусад улстай байгуулсан давхар татварын гэрээний хэрэгжилтийг хянан үзсэний дагуу Нидерландын Вант Улс, Люксембургийн Их Гүнт Улс, Арабын Нэгдсэн Эмират Улс, Кувейт улстай байгуулсан давхар татварын гэрээнүүдийг цуцлахаар холбогдох саналыг УИХ-д өргөн мэдүүлнэ.	2012-2016	СЯ	ГХЯ ЭЗХЯ	Холбогдох яам		УИХ-аар шийдвэрүүлсэн байна.
		2	БНХАУ, Канад Улс болон Бүгд Найрамдах Сингапур Улстай байгуулсан давхар татварын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хэлэлцэн тохирогч улсуудтай хэлэлцээр хийж, саналаа холбогдох төслийг УИХ-д өргөн мэдүүлнэ.	2012-2016	СЯ	ГХЯ ЭЗХЯ	Холбогдох яам		УИХ-аар шийдвэрүүлсэн байна.
26.	Уул уурхай, ашигт малтмал, нефтийн бүтээгдэхүүний импорт, газрын тосны экспорт, үүрэн холбооны операторын үйлчилгээ, архи, спирт, тамхи зэргээс бусад салбарт үйл	1	Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжийн орлогын албан татварын талаар санал боловсруулж, холбогдох зохицуулалт хийнэ.	2013-2016	ХЯ	СЯ ХЗЯ	АНЗД МУХАУТ АОЭНХ	61.200.0 /буцаан олголт эдлэх/	Зохицуулалт бий болсон байна.

	ажиллагаа явуулдаг, жилийн борлуулалтын орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс илүүгүй аж ахуйн нэгжид төсөвт төлсөн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 90 хувийг буцаан олгох	2	Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн татварыг хялбаршуулж, хувь хэмжээг бууруулах зарчмыг баримтлан хэрэгжүүлнэ.	2012-2014	СЯ				Татварын хэмжээ буурсан байна.
27.	Төсвийн хөрөнгөөр худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээг нийлүүлэх аж ахуйн нэгжид нийт борлуулалтын гучаас доошгүй хувийг өөрийн үйл ажиллагааны орлогоос олдог байх шаардлага тавих;	1	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, үүнтэй уялдуулан тендерийн бичиг баримт, үнэлгээний зааварт холбогдох өөрчлөлтийг оруулан, төсвийн ерөнхийлөн захирагч нараар мөрдүүлж ажиллана.	2012-2015	СЯ	ХААГ	ТЕЗ	20.0 Улсын төсөв	Шаардлага хангасан оролцогчидтой гэрээ байгуулдаг журамд шилжсэн байна.
28.	Гадаадын төрийн өмчит компаниудын хөрөнгө оруулалтыг хянан зохицуулсан бодлого хэрэгжүүлэх	1	Стратегийн ач холбогдол бүхий салбарт холбогдох хэлцэл хийх гадаадын хөрөнгө оруулагчдын хүсэлтийг хүлээн авах, нягтлах, шийдвэр гаргах журмыг Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль, Өрсөлдөөний тухай хуульд нийцүүлэн баталж хэрэгжүүлнэ.	2013	ЭЗХЯ	ШӨХТГ		Улсын төсөв	Журам хэрэгжиж эхэлсэн байна.
29.	Хувийн хэвшилтэй хамтран бизнес форум тогтмол зохион байгуулж, тодорхой асуудлуудыг шийдвэрлэх	1	Эдийн засгийн форумыг үргэлжлүүлэн жил бүр зохион байгуулна.	2012-2016	ЭЗХЯ				Форумыг жил бүр зохион байгуулсан байна.
		2	Хувийн хэвшил болон төрийн бус байгууллагатай хамтран "Хот байгуулалтын форум", "Газрын харилцаа, геодези, зураг зүйн форум"-ыг жил бүр зохион байгуулна.	2012-2016	БХБЯ		ТББ ХХ		Форумыг зохион байгуулж хэвшсэн байна.
		3	"QUALITY-MONGOLIA" олон улсын форумыг зохион байгуулан хоёр жил тутамд тогтмол хийдэг болно.	2013-2016	СХЗГ				Форумыг зохион байгуулсан байна.
30.	Хөдөлмөрийн багтаамж ихтэй салбаруудыг бодлогоор дэмжиж ажлын байр нэмэгдүүлэх	1	Хөнгөн үйлдвэрийн талаар төрөөс баримтлах бодлого боловсруулна.	2013-2014	ҮХААЯ	ЭЗХЯ ХЯ			Бодлого боловсруулсан байна.
		2	Оёдол, нэхмэл, сүлжмэлийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэхэд зээлийн бодлогоор дэмжиж, борлуулалтад нь дэмжлэг үзүүлнэ.	2012-2016	ҮХААЯ	ХЯ		120.000.0 Улсын төсөв	Ажлын байр 20000-аар нэмэгдсэн байна.
		3	Боловсрол, эрүүл мэнд, уул уурхайн салбарт шаардлагатай оёмол бүтээгдэхүүнийг үндэсний аж ахуйн нэгжүүдээр гүйцэтгүүлэх бодлого баримтлан зээлийн дэмжлэг үзүүлнэ.	2012-2014	ҮХААЯ	БШУЯ		119.300.0 Улсын төсөв	Оёмол бүтээгдэхүүний тоо хэмжээ өссөн байна.
		4	Аялал жуулчлалын салбарт ажлын байр нэмэгдүүлэх, үндэсний соёлын брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжийг дэмжих бодлого баримтална.	2013-2016	ХЯ	ССАЖЯ	АНЗД	30.000.0 ЖДҮХС Улсын төсөв	Аялал жуулчлалын салбарт ажлын байр нэмэгдсэн байна.

		5	“Барилгын салбарын хөдөлмөр зуучлалын алба”-ыг өргөжүүлж үйл ажиллагааг нь идэвхжүүлнэ.	2012-2014	БХБЯ		ТББ ХХ	100.0 Улсын төсөв	Албыг өргөжүүлэн зохион байгуулсан байна.
		6	Улаанбаатар хот, аймгийн төвд цаас, хэвлэлийн туслах материал, сав, баглаа боодлын үйлдвэрийг цаасан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн парк хэлбэрээр хөгжүүлнэ.	2012-2014	ҮХААЯ		ТББ ХХ	35.500.0 Улсын төсөв	Дотоодын зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээ нэмэгдсэн байна.
		7	Ойн хаягдлыг ашиглан шахмал хавтан, шахмал түлш үйлдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.	2012-2015	ҮХААЯ	БОНХЯ		86.000.0 Улсын төсөв	Шахмал хавтан, түлш үйлдвэрлэдэг болсон байна.
31.	Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн салбарыг бие даасан, цөөн орноос хамааралтай байдлыг арилгахад анхаарч өрсөлдөх чадварыг нь бэхжүүлэх	1	“Хүнс, хөдөө аж ахуйн талаар төрөөс баримтлах бодлого”-ыг шинэчилж, бүтээмжийг нэмэгдүүлж өрсөлдөх чадварыг бэхжүүлэх эрх зүй, эдийн засгийн таатай орчинг бүрдүүлнэ.	2013-2015	ҮХААЯ		ТББ		Бодлогыг шинэчлэн баталж, хэрэгжүүлж эхэлсэн байна.
		2	Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлнэ.	2013-2015	ҮХААЯ	БШУЯ ЭЗХЯ	ОУБ ТББ	4.000.0 Улсын төсөв	Дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлсэн байна.
32.	Хөрөнгийн биржийн үйл ажиллагааг дэмжиж иргэд, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах	1	Хөрөнгийн биржийн үйл ажиллагааг зохицуулсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.	2013-2014	ЭЗХЯ	СЗХ	МХБ		Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
33.	Зээлийн батлан даалтын сангаар дамжуулан жижиг бизнесийг дэмжих	1	Зээлийн батлан даалтын санг үүсгэн байгуулж, дүрмийг батлан үйл ажиллагааг нь эхлүүлнэ.	2013-2016	ХЯ	СЯ СЗХ	АНЗД төсөл хөтөлбөр	27.000.0 ЗБДС	Сангийн үйл ажиллагаа эхэлсэн байна.
		2	Зээлийн батлан даалтыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах дүрэм, журмуудыг боловсруулан батлуулах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах.	2013-2016	ХЯ	СЯ СЗХ			Дүрэм, журмуудыг баталсан байна.
		3	Зээлийн батлан даалтын сангийн эх үүсвэрт зориулан жил бүр тодорхой хэмжээний хөрөнгийг улсын төсөвт тусгана.	2012-2016	СЯ	ҮХААЯ		40.000.000	Хөрөнгө төсөвт тусгагдсан байна.
34.	Хөдөө, аж ахуйн биржийн тухай хууль, Улсын Их Хурлаас баталсан “Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот хөтөлбөр”, “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”, Засгийн газраас баталсан “Хүнсний аюулгүй байдал”, “Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр”-үүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх	1	Биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалтыг баталж, биржийн барааны стандартыг мөрдүүлэх, итгэмжлэгдсэн агуулах бий болгоно.	2012-2016	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ		25.000.0 Улсын төсөв	Итгэмжлэгдсэн агуулах, тээврийг бий болгосон байна.
		2	Биржийн барааг шалгах итгэмжлэгдсэн лабораторийн чадавхийг дээшлүүлж, хөдөө аж ахуйн хоршоодыг биржийн арилжаа явуулах онлайн сүлжээтэй болгож, шаардагдах тоног төхөөрөмжөөр хангана.	2012-2013	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ МТШХХГ		15.000.0	Лабораторийн чадавхи сайжирч, хоршоодыг тоног төхөөрөмжөөр

								хангаж, онлайн сүлжээтэй болгосон байна.
3	Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.	2012-2014	БХБЯ	ХЗЯ				Хуулийн төслийг өргөн мэдүүлсэн байна.
4	"Барилгын салбарыг 2013-2020 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө"-г батлан хэрэгжүүлнэ.	2013-2016	БХБЯ	ЭЗХЯ СЯ		35.0 БСННС		Төлөвлөгөө батлагдсан байна.
5	Орон сууцны багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.	2013-2014	БХБЯ	ХЗЯ				Хуулийн төслийг өргөн мэдүүлсэн байна.
6	Барилгын материалын сорил шинжилгээний лаборатори байгуулах асуудлыг цогц байдлаар шийдвэрлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.	2012-2016	БХБЯ	СЯ	ТББ ХХ	58.000.0 Улсын төсөв		Лабораториудыг байгуулсан байна.
7	Барилгын материалын парк, бөөний худалдааны сүлжээг Замын-Үүд, Улаанбаатар хотод байгуулна.	2013-2016	БХБЯ	ЭЗХЯ	НЗД Дорноговь АЗД ХХ	61.200.0 ХБ		Парк, бөөний худалдааны сүлжээ байгуулагдсан байна.
8	Орон нутагт барилгын материалын түүхий эдийн геологи хайгуул хийж, нөөцийг тогтооно.	2012-2014	БХБЯ	ҮХААЯ ЭЗХЯ СЯ	ТББ ХХ	12.000.0 Улсын төсөв ХХО		Нөөцийг тогтоосон байна.
9	Орон нутгийн түгээмэл тархацтай түүхий эдийн нөөцөд тулгуурлан нийслэлд 10, аймаг тус бүрт 3-5 нэр төрлийн барилгын материалын үйлдвэрийг шинэчлэх болон шинээр байгуулна.	2012-2016	БХБЯ	ЭЗХЯ ҮХААЯ	ХХ	355.900.0 ХБ ХХ		Нийслэлд 10, аймаг тус бүрт 3-5 үйлдвэрийг байгуулсан байна.
10	Нийтийн зориулалттай орон сууцны лифт засварын цех байгуулж, ашиглалтын шаардлага хангахгүй 100-аас доошгүй лифтийг жил бүр шинэчилнэ.	2012-2016	БХБЯ	МХЕГ	АНЗД ТББ ХХ	15.000.0 Улсын төсөв		400-аас доошгүй лифт шинэчилсэн байна.
11	Улаанбаатар хотын төвийн хөдөлгөөний нягтрал ихтэй хэсгүүдэд газар доорх инженерийн шугам сүлжээг хонгилын системтэйгээр төлөвлөж, шинэчлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.	2012-2016	БХБЯ	ЭХЯ	НЗД	99.200.0 Улсын төсөв		Шугам сүлжээг хонгилын системд шилжүүлэх ажил эхэлсэн байна.
12	Нийслэл, аймгийн төв, суурин газруудын инженерийн барилга байгууламж, шугам сүлжээний мэдээллийн сан байгуулна.	2012-2016	БХБЯ		АНЗД	1.700.0 Улсын төсөв		Мэдээллийн сантай болсон байна.
13	Улаанбаатар хотод ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 180 айлын орон сууц барих ажлыг зохион байгуулна.	2013-2014	БХБЯ	ХАХНХЯ	НЗД	10.000.0 Улсын төсөв		180 айлын орон сууц баригдсан байна.
14	Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгуудыг буулган шинээр 15800 айлын орон сууц барина.	2012-2016	БХБЯ	МХЕГ	АНЗД	742.900.0 ХХ		15800 айлын орон сууц баригдсан байна.
15	Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийг	2013-2016	БХБЯ	БОНХЯ	НЗД	9.000.0 Улсын төсөв		Төв цэвэрлэх байгууламжийн

			шинэчлэх ажлыг зохион байгуулж, хаягдал ус, лагийг дахин ашиглах технологийг нэвтрүүлнэ.						тоног төхөөрөмжийг шинэчилсэн байна.
		16	Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарт хэрэгжсэн хандивлагч орнуудын төсөл, хөтөлбөрийн хүрээнд бий болсон зээлийн асуудлыг шийдвэрлэнэ.	2012-2013	БХБЯ	ХЗЯ СЯ	АНЗД		Зээлийн асуудал шийдэгдсэн байна.
		17	Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тодотголыг боловсруулж батална.	2012-2013	БХБЯ	СЯ	АНЗД	650.0 Улсын төсөв	Тодотгол батлагдсан байна.
		18	Шинээр барихаар төлөвлөж байгаа төмөр замын дагуу GPS-ийн сүлжээ байгуулах, 1:25000 масштабтай байр зүйн зураглалыг боловсруулна.	2012-2013	БХБЯ	СЯ	АНЗД	14.140.0 Улсын төсөв	Байр зүйн зураглалыг боловсруулсан байна.
		19	Инженер, техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчид бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх болон үйлдвэрлэл эрхлэгчдэд удирдлагын дадлага, ур чадвар эзэмшүүлэх тогтолцоог бий болгох, бэхжүүлэх замаар шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлнэ.	2013-2016	ХЯ	БШУЯ ҮХААЯ			Тогтолцоо бий болсон байна.
		20	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв, бизнес инкубаторыг аймаг бүрт байгуулж, үйл ажиллагааг өргөжүүлнэ.	2013-2016	ХЯ	СЯ		47.700.0 Улсын төсөв	Төв, бизнес инкубаторыг аймаг бүрт байгуулсан байна.
		21	Агаарын бохирдол ихтэй томоохон хот, аймгийн төвд 5-аас доошгүй агаарын чанарыг тодорхойлох автомат станц байгуулна.	2013-2016	БОНХЯ		АЗД	7.000.0 Улсын төсөв	5-аас доошгүй станц суурилуулсан байна.
35.	Санхүүгийн секторын шинэтгэлийг бодит сектор, тухайлбал, уул уурхайн бус эдийн засгийн бусад салбар, жижиг, дунд бизнесийн өсөлтийг дэмжих, хувийн даатгалын ба хөрөнгө оруулалтын сангууд, хувийн тэтгэврийн сангийн болон зээлийн батлан даалтын тогтолцоог хэрэгжүүлэх чиглэлээр орчин үеийн санхүүгийн зах зээлийн өрсөлдөөнт орчныг бий болгоход чиглүүлэх	1	Орчин үеийн санхүүгийн зах зээлийн өрсөлдөөнт орчныг бий болгоход чиглэсэн хууль эрх зүйн орчныг бий болгоно.	2012-2016	СЯ	ХЯ СЗХ	Монголбанк	80.000.000	Эрх зүйн орчин бүрдсэн байна.
		2	Хувийн тэтгэврийн даатгалыг улсын тэтгэврийн даатгалын тогтолцооны нэмэлт давхарга хэлбэрээр хөгжүүлэх хууль эрх зүйн орчинг бүрдүүлнэ.	2013-2014	ХАХНХЯ	ЭЗХЯ СЗХ	Монголбанк		Эрх зүйн орчин бүрдсэн байна.
		3	Хувийн тэтгэврийн даатгалын сангуудын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтад хяналт тавих тогтолцоо бий болгож, сангуудын эрсдэлийг бууруулан, хувийн тэтгэврийн сангаар дамжуулан санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжинэ.	2013-2014	ХАХНХЯ	ЭЗХЯ СЗХ	Монголбанк		Сангуудыг хянах чиг үүрэг бүхий бүтцийн нэгж бий болсон байна.
		4	Хувийн шууд болон шууд бус хөрөнгө оруулалтын сангийн тогтолцоог бүрдүүлэх зэрэг санхүүгийн зах зээлийн өрсөлдөөнт орчныг бий болгоход чиглэсэн зохицуулалт, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно	2013-2014	СЗХ	ЭЗХЯ	Монголбанк		Сангийн үйл ажиллагааны эрх зүйн орчин бүрдсэн байна.

		5	Гадаад зах зээлээс хямд эх үүсвэрийг боломжтой хэмжээгээр татаж, зөвхөн бүтээн байгуулалтын төслүүдийг санхүүжүүлнэ.	2012-2015	ЭЗХЯ	СЯ			Бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт нэмэгдсэн байна.
		6	Засгийн газрын үнэт цаасыг гаргаж гадаад зах зээл дээр арилжих арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.	2012-2015	ЭЗХЯ				Үнэт цаасыг арилжаалсан байна.
		7	Гадаадын нэр хүндтэй банк, хөрөнгө оруулалтын сангуудаас хүү багатай урт хугацааны зээл авах гэрээ байгуулж ажиллана.	2012-2015	ЭЗХЯ				Гэрээ, хэлэлцээр байгуулсан байна.
		8	Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой заавар, журмыг боловсруулж мөрдүүлнэ.	2012-2013	ЭЗХЯ	ХЯ ҮХААЯ БХБЯ ЗТЯ ССАЖЯ			Заавар, журмыг батлан мөрдүүлсэн байна.
		9	Зээлийн батлан даалтын үйл ажиллагаа явуулах хувийн хэвшлийн компаниудыг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.	2012-2015	ЭЗХЯ	ХЯ ҮХААЯ БХБЯ			Дэмжлэг үзүүлсэн байна.
36.	Олон улсын нэр хүндтэй банк орж ирэх нөхцөлийг бүрдүүлэх	1	Олон улсын нэр хүндтэй банк орж ирэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор гэрээ хэлэлцээр байгуулах, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.	2013-2015	ЭЗХЯ				Хууль баталж, гэрээ, хэлэлцээр байгуулсан байна.
37.	Нутаг дэвсгэрийн геологийн зураглал, эрэл, хайгуулын ажилд зарцуулж байгаа улсын төсвийн хөрөнгө оруулалтыг жил бүр нэмэгдүүлж, геомэдээллийн санг баяжуулах, эрдэс баялгийн нөөцийг өсгөн нэмэгдүүлэх замаар уул уурхайн салбарыг тогтвортой хөгжүүлэх бодлогыг дэмжих	1	Ашигт малтмалын хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг өсгөн нэмэгдүүлж, хайгуулын ажлыг ерөнхий болон нарийвчилсан үе шаттайгаар хийж, улсын эрдэс баялгийн сан хөмрөгийг өсгөн нэмэгдүүлнэ.	2012-2016	УУЯ	СЯ		3.000.0 Улсын төсөв	Улсын төсвийн хөрөнгөөр илрүүлсэн нөөц өссөн байна.
2		1:200 000 масштабын геологийн иж бүрдэл зураг төслийг Монгол Улсын хэмжээнд үргэлжлүүлэн хэрэгжүүлж, нийт нутаг дэвсгэрийг 100 хувь хамруулна. Үүнд: - 2012-2014 онд Баруун Монгол-V, Төв Монгол-IV, Өмнөд Монгол-VI, Дорнод Монгол-V төсөл, - 2013-2016 онд Төв Монгол-V, Дорнод Монгол-VI, VII төсөл, - 2014-2016 онд Төв Монгол-VI, VII төсөл.	2012-2016	УУЯ	СЯ	ААН	3.500.0 Улсын төсөв	2016 онд нийт нутаг дэвсгэрийг 100 хувь хамруулсан байна.	
3		Монгол орны баруун бүсэд цул сульфидын хүдэржилтийн тархалтыг судалж, 1:1 000 000 масштабын хэтийн төлөвийн зураг зохиох, үнэлгээ өгөх, цаашдын судалгааны объектыг тодруулах төсөл хэрэгжүүлнэ.	2014-2016	УУЯ	СЯ			450.0 Улсын төсөв	Алслагдсан баруун бүс нутагт цул сульфидын хүдэржилтийн тархалт, хэтийн төлөвийг тогтоосон байна.

		4	Баян-Өлгий, Ховд аймгийн нутгийг хамарсан М-45-XXXVI, М-46-XXXI, L-46-I, II, L-46-VII, VIII хавтгайд 1:200000-ны масштабтай агаарын геофизикийн цогцолбор судалгааны ажлыг Ховд-I талбайд шинээр хийнэ.	2014-2016	УУЯ	ЭЗХЯ СЯ		5.400.0 Улсын төсөв	Судалгааны ажил хийгдсэн байна.
		5	Эрдэс, чулуулгийн лабораторийн шинжилгээ, судалгааг боловсронгуй болгож, олон улсын түвшинд хүрсэн чанарын болон тоон шинжилгээг иж бүрэн хийдэг болно.	2012-2016	УУЯ			2.000.0 Улсын төсөв	Олон улсын жишигт хүрсэн лабораторитай болсон байна.
		6	Монгол орны бүс нутгийн металлогени, ашигт малтмалын ордын төрлүүдийн тархан байршлын зүй тогтлын 1:1000000 масштабын зураг зохионо.	2013-2016	УУЯ			500.0 Улсын төсөв	Зураг зохиогдсон байна.
		7	Монгол орны геологийн тогтоц, ашигт малтмалын ерөнхий тархалтыг сансрын зураг ашиглан нэгдсэн боловсруулалт, тайлалт хийнэ.	2013-2016	УУЯ			1.000.0 Улсын төсөв	Нэгдсэн боловсруулалт, тайлалт хийсэн байна.
		8	Олон талын зориулалттай тандан судалгааны хиймэл дагуулын мэдээ хүлээн авах газрын станц байгуулна.	2012-2016	МТШХХГ	УУЯ БХБЯ БОНХЯ		30.000.0 Улсын төсөв Гадаадын зээл	Газрын станц байгуулсан байна.
38.	Нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийг судлах зорилгоор улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа 1:50 000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажилд 2016 онд нийт нутаг дэвсгэрийн 40 хувийг хамруулах	1	1:50 000-ны масштабаар геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг эдийн засгийн бүсчлэл, дэд бүтцийг харгалзан тодорхой тектоник, металлогенийн бүсүүдийн хэмжээнд үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	2012-2016	УУЯ	СЯ ЭЗХЯ		35.000.0 Улсын төсөв	2016 онд нийт нутаг дэвсгэрийн 40 хувийг хамруулсан байна.
		2	Өндөр нарийвчлал бүхий тандан судалгааны хиймэл дагуул хөөргөх төслийг хэрэгжүүлнэ.	2012-2015	МТШХХГ	УУЯ БХБЯ БОНХЯ		350.000.0 Улсын төсөв Гадаадын зээл	Хиймэл дагуул хөөргөсөн байна.
39.	Геологийн салбарын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох ажлын хүрээнд Монголын Үндэсний геологийн албыг шинээр байгуулах	1	Монголын Үндэсний геологийн албыг шинээр байгуулах асуудлыг судалж шийдвэрлэнэ.	2012-2013	УУЯ			25.000.0 Улсын төсөв	Асуудлыг судалж, шийдвэрлэсэн байна.
40.	Эрдэс баялгийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох	1	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход орон нутгийн иргэдийн оролцоог хангах талаар Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусган боловсруулна.	2013	УУЯ	ЗГХЭГ	АЗД ИТХ		Иргэдийн оролцоог хангах эрх зүйн орчин бүрдсэн байна.
		2	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох саналыг шийдвэрлэхэд тухайн баг, сумын иргэдийн оролцоог хангах асуудлыг хэрэгжүүлнэ.	2013	ЗГХЭГ	УУЯ	АЗД	25.000.0 Улсын төсөв	Орон нутгийн иргэдийн оролцоо хангагдсан байна.
		3	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг салбарын төрийн захиргааны	2012-2016	УУЯ			50.000.0 Улсын төсөв	Хуулийн төслийг УИХ-д өргөн

			төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газрын шийдвэрээр олгодог болгох талаар судалж, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусган боловсруулна.						мэдүүлсэн байна.
		4	Аж ахуйн нэгж, хуулийн этгээдэд олгох ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн тоонд хязгаарлалт тавих эрх зүйн орчныг судалгаанд үндэслэн бүрдүүлнэ.	2012-2016	УУЯ				Эрх зүйн орчин бүрдсэн байна.
		5	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгож болохгүй газар нутгийг судалж, хил хязгаарыг тогтооно.	2012-2016	БОНХЯ	УУЯ		500.0	Хил хязгаарыг тогтоон баталсан байна.
		6	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг орон нутгийн саналд тулгуурлан зөвхөн төрөөс тогтоосон нутаг дэвсгэрт олгодог болгох чиглэлээр эрх зүйн орчин бүрдүүлнэ.	2012-2016	УУЯ				Эрх зүйн орчин бүрдсэн байна.
		7	Татварын зохицуулалтыг хийх замаар түүхийгээр гаргаж байгаа уул уурхайн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлнэ.	2012-2016	УУЯ		ТББ	30.000.0 Улсын төсөв	Эрх зүйн орчин бүрдсэн байна.
		8	Уул уурхайн олборлох үйлдвэрийн бүтээгдэхүүнийг зах зээлийн үнээр тэргүүн ээлжинд дотоодын боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлдэг болно.	2012-2016	УУЯ				Эрх зүйн орчин бүрдсэн байна.
		9	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийгдсэн стратегийн ордууд дээр байгуулагдах компанийн 51-ээс доошгүй хувийг Монголын тал эзэмших талаар Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгана.	2012-2016	УУЯ	ЭЗХЯ СЯ		25.000.0 Улсын төсөв	Эрх зүйн орчин бүрдсэн байна.
		10	Байгаль орчны аудитаар дамжуулж уул уурхайн үйлдвэрлэлд байгаль орчинд сөрөг нөлөөлөл ихтэй технологийг ашиглуулахгүй байх арга хэмжээг авна.	2013-2016	БОНХЯ	УУЯ СХЗГ	АНЗД	300.0 Улсын төсөв	Уурхайнуудад аудит хийж байгаль орчинд сөрөг нөлөөтэй технологийг ашиглуулахгүй болсон байна.
		11	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд тавигдах шаардлагыг өндөржүүлж, нөлөөллийн үнэлгээгээр олборлолт, ашиглалтын технологи нь байгаль орчинд сөрөг нөлөөлөл ихтэй уурхайн технологи, стандартын мөрдөлтөд аудит хийж тодорхой арга хэмжээ авна.	2013-2016	БОНХЯ	УУЯ ЭЗХЯ		800.0	Жилд 250-иас доошгүй уул уурхайн төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хянаж, аудитын дүгнэлтээр арга хэмжээ авсан байна.

		12	Ашигт малтмалын төрөл, олборлох, боловсруулах технологийн онцлогийг тусгасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх Европын Холбооны стандартыг нутагшуулж мөрдүүлнэ.	2013-2016	БОНХЯ	УУЯ		350.0 Улсын төсөв	Нийт 9 стандарт, 2 аргачлал, 2 журмыг шинээр болон шинэчлэн боловсруулсан байна.
		13	Ашигт малтмалын олборлолт явуулах үед байгаль орчныг хамгаалах болон олборлолт явуулсны дараа байгаль орчныг нөхөн сэргээх зардлыг төрийн санд урьдчилан төвлөрүүлдэг болгоно.	2012-2014	УУЯ	БОНХЯ	ХО	30.000.0 Улсын төсөв	Нөхөн сэргээх зардлыг төрийн санд урьдчилан төвлөрүүлдэг болсон байна.
		14	Ашигт малтмалын тухай хуульд заасан стратегийн ач холбогдол бүхий ордын тодорхойлолтыг судалгаанд үндэслэн боловсронгуй болгож, эрчим хүчний болон коксжих нүүрс, зэс, төмрийн хүдэр, газрын ховор элемент зэргийг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ангилалд оруулна.	2012-2016	УУЯ	ЭХЯ		25.000.0 Улсын төсөв	Ангилалд оруулах арга хэмжээ авсан байна.
		15	Геологийн хувьд нэгдмэл тогтоцтой ордуудын тусгай зөвшөөрлийг хэсэгчилж олгохгүй байх асуудлыг шийдвэрлэнэ.	2012-2016	УУЯ			25.000.0 Улсын төсөв	Хэсэгчилсэн зөвшөөрөл олгоогүй байна.
		16	Нэгдмэл тогтоцтой ордыг иж бүрэн ашиглах байгальд ээлтэй технологийг судалж нэвтрүүлэхийг дэмжинэ.	2012-2016	УУЯ				Технологийг нэвтрүүлж эхэлсэн байна.
41.	Эрдэс баялгийн экспортыг нэгдсэн "Нэг цонх"-ны бодлогоор хэрэгжүүлэх	1	Ашигт малтмалыг экспортод гаргахтай холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлж, эрдэс баялгийн экспортыг нэгдсэн "Нэг цонх"-ны бодлогоор хэрэгжүүлэх арга хэмжээ авна.	2012-2016	УУЯ			50.000.0 Улсын төсөв	"Нэг цонх"-ны бодлого хэрэгжиж эхэлсэн байна.
42.	Уул уурхайн салбарт хэрэгжиж байгаа төслүүдэд үндэсний аж ахуйн нэгжүүд давуу эрхээр бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх, туслан гүйцэтгэгчээр ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэх	1	Уул уурхайн салбарт хэрэгжиж байгаа төслүүдэд үндэсний аж ахуйн нэгжүүд давуу эрхээр бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх, туслан гүйцэтгэгчээр оролцох, үндэсний хэмжээний нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлэхтэй холбогдсон арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	2012-2016	УУЯ	ЭЗХЯ ХЗЯ		20.000.0 Улсын төсөв	Эрх зүйн орчин бүрдсэн байна.
43.	Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын жагсаалтыг шинэчлэн, томоохон орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулахыг эрчимжүүлэх. Стратегийн ач холбогдол бүхий ордын төрийн эзэмшлийг нэгтгэн, корпорацийн зохион байгуулалтад оруулж, Хүний хөгжил сангийн тухай хуулийн дагуу иргэдэд давуу эрхийн хувьцаа олгоно.	1	Ашигт малтмалын тухай хуулийн стратегийн ач холбогдол бүхий ордын тодорхойлолтыг судалгаанд үндэслэн боловсронгуй болгосны үндсэн дээр стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын жагсаалтыг шинэчлэн батлуулна.	2013-2014	УУЯ	ЭЗХЯ		20.000.0 Улсын төсөв	Жагсаалт батлагдсан байна.
		2	Стратегийн ач холбогдол бүхий ордын төрийн эзэмшлийг нэгтгэн, корпорацийн зохион байгуулалтад оруулна.	2013-2014	УУЯ	ЭЗХЯ			Корпорацийн зохион байгуулалтад оруулсан байна.
		3	Стратегийн орд газарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдтэй төрийн	2013-2014	УУЯ	ЭЗХЯ СЯ			Гэрээ байгуулсан байна.

			эзэмшлийн хувийг тогтоох хэлэлцээ хийж, улмаар ордыг ашиглах гэрээний төслийг хууль тогтоомжид заасны дагуу бэлтгэх арга хэмжээ авна.						
		4	"Эрдэнэс МГЛ" ХХК-ийг өөрчлөн байгуулж, хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлнэ. Стратегийн ач холбогдол бүхий ордод үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн төрийн эзэмшлийг шийдвэрлэх арга хэмжээ авна.	2013	УУЯ	СЯ ҮХААЯ	"Эрдэнэс МГЛ" ХХК		Хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлсэн байна.
		5	"Эрдэнэс МГЛ" ХХК-ийн давуу эрхийн хувьцааг иргэн бүрт эзэмшүүлэх асуудлыг эцэслэн шийдвэрлэнэ.	2012	ЭЗХЯ		"Эрдэнэс МГЛ" ХХК		Иргэдэд хувьцааг эзэмшүүлсэн байна.
		6	Гурванбулаг, Дорнод, Хараат, Хайрхан, Гурвансайхан, Өлзийт, Дулаан-Уул, Зөөвч овоо ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулна.	2012-2016	ЦЭГ	УУЯ	"Мон Атом" ХХК ААН	Улсын төсөв ХХ	Ордуудыг эргэлтэд оруулсан байна.
		7	Цацраг идэвхт ашигт малтмалын орд газруудыг түшиглэн Дорноговь, Дундговь, Дорнод аймгуудад боловсруулах үйлдвэр барьж байгуулах ажлыг зохион байгуулна.	2012-2016	ЦЭГ	УУЯ	ХО		Үйлдвэрүүдийг барьж байгуулсан байна.
		8	Цацраг идэвхт ашигт малтмалын чиглэлээр Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд гүйцэтгэж байгаа бүх төрлийн геологийн судалгааны ажлуудын үр дүнг нэгтгэж, олон улсын жишигт хүрсэн, стандартын шаардлагад нийцсэн, үндэсний мэдээллийн санг бүрдүүлнэ.	2012-2015	ЦЭГ	УУЯ	ШУТИС МУИС	Улсын төсөв	Мэдээллийн сан бүрдүүлсэн байна.
44.	Алтны олборлолт, хадгалалт, борлуулалтыг ил тод болгох	1	Алтны олборлолт, хадгалалт, борлуулалтыг ил тод болгох механизмыг бүрдүүлэх асуудлыг алт олборлогч аж ахуйн нэгж, байгууллага, Монголбанкт хамтран зохион байгуулж хэрэгжүүлнэ.	2012-2016	УУЯ	Монголбанк		50.000.0 Улсын төсөв	Алтны олборлолт, хадгалалт, борлуулалтыг ил тод болгосон байна.
		2	Үнэт металлын дээж хадгалах журам баталж мөрдүүлнэ.	2012-2013	СХЗГ	СЯ Монголбанк		Улсын төсөв	Журам баталсан байна.
		3	Сорьц тогтоох лабораторид шинжлүүлсэн үнэт металлыг Монголбанк руу зөөвөрлөх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.	2013-2014	СХЗГ	СЯ Монголбанк		Улсын төсөв	Эрх зүйн орчныг боловсронгуй болгосон байна.
		4	Үнэт металлын сорьцын хяналтын үйл ажиллагааг олон улсын түвшинд нийцүүлж Олон Улсын сорьцын хяналтын байгууллагад гишүүнээр элсэнэ.	2012-2014	СХЗГ			Улсын төсөв	ОУБ-ын гишүүнээр элссэн байна.
45.	Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг боловсронгуй болгож, хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах	1	Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журамд орон нутгийн удирдлагын хүлээх хариуцлагыг тодорхой тусгаж, хэрэгжилтэд нь тавих хяналтыг сайжруулах чиглэлээр холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулна.	2012-2013	УУЯ	МХЕГ		Улсын төсөв	Журам батлагдсан байна.

46.	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга болон хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх санаачилга, тэдгээрийн зарчмууд болон стандартыг нэвтрүүлэх	1	“Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-ын зарчим болон шалгуурыг хувийн хэвшил, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, ил тод байдлыг хангана.	2012-2016	УУЯ	СЯ			Зарчим, шалгуурыг нэвтрүүлсэн байна.	
		2	“Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх санаачилга”-ын зарчим, стандартыг төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.	2012-2016	УУЯ				Зарчим, стандартыг нэвтрүүлсэн байна.	
47.	Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, олборлох, ашиглахыг хориглох тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, байгальд ээлтэй уул уурхайг хөгжүүлэх	1	Засгийн газраас баталсан хил хязгаарын дагуу хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллана.	2012-2016	УУЯ				Хууль хэрэгжсэн байна.	
		2	Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулсан хохирлын үнэлгээг хийж, олон улсын стандартын дагуу нөхөн сэргээлт хийх зардлын тооцоог тусгай зөвшөөрөл бүрт тооцож хэрэгжүүлнэ.	2013-2015	БОНХЯ	УУЯ	7.800.0 Улсын төсөв		Хуулиар хориглосон талбайд экологийн хохирлыг тусгай зөвшөөрөл бүрээр гаргаж, нөхөн сэргээлтийг хийлгэсэн байна.	
48.	Байгалийн нөөцийн эдийн засгийн статистикийг шинэчилж, улсын эдийн засаг, санхүүд эрдэс баялгийн салбарын үзүүлж байгаа нөлөөллийн үзүүлэлтийг системтэй тооцоолох аргачлалыг холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран хэрэгжүүлэх тогтолцоог бий болгох	1	Байгаль орчны эдийн засгийн судалгаа хийж, статистик үзүүлэлтийг боловсронгуй болгон үндэсний тооцооны системд тусгах арга хэмжээ авна	2012-2016	БОНХЯ	ЭЗХЯ ҮСХ	500.0		Тогтолцоо бүрдсэн байна.	
49.	Эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг хангахын тулд ашигт малтмалыг түүхий эд хэлбэрээр гаргахыг үе шаттай багасгах, түүнчлэн экспортолж байгаа бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг олон улсын стандартад нийцүүлэн шат дараатай ахиулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх бодлого баримтлах	1	Экспортод гаргаж байгаа уул уурхайн бүтээгдэхүүний стандартыг олон улсын жишигт нийцүүлэх талаар судалгаа хийж хэрэгжүүлнэ.	2012-2016	УУЯ				Стандартыг олон улсын жишигт хүргэн мөрдүүлсэн байна.	
		2	Уул уурхайн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийг гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	2013	ҮХААЯ	УУЯ СЯ ХЗЯ			Эрх зүйн орчин бүрдсэн байна.	
		3	Зэсийн баяжмалыг боловсруулан цэвэр зэс үйлдвэрлэх технологийн сонголт хийж, үйлдвэрийн ТЭЗҮ-ийг олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтаар гүйцэтгүүлнэ.	2015-2016	ҮХААЯ	ЭЗХЯ	“Эрдэнэт үйлдвэр” ХХК	1.300.0		ТЭЗҮ-ийг боловсруулах сонгон шалгаруулалтыг явуулсан байна.
		4	Зүүн бүст полиметаллын баяжмалыг боловсруулан цайр болон бусад дагалдах элементийг ялган авах үйлдвэрийг барьж байгуулах асуудлыг судалж шийдвэрлэнэ.	2013-2014	ҮХААЯ	ЭЗХЯ	ТББ			Урьдчилсан ТЭЗҮ-ийг боловсруулсан байна.
		5	Экспортод гаргаж байгаа бүрэн	2012-2016	УУЯ	ҮХААЯ		Улсын төсөв		Эрх зүйн орчин

			боловсруулаагүй хүдэр болон баяжмалыг боловсруулалтын түвшинг нь харгалзан экспортын татвар ногдуулах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.			МХЕГ			бүрдсэн байна.
50.	Дархан-Сэлэнгийн бүсийн төмрийн хүдрийн ордуудыг түшиглэн орчин үеийн техник, технологи бүхий төмөрлөгийн цогцолбор үйлдвэр барих	1	Дархан-Сэлэнгийн бүс нутгийн төмрийн хүдрийн ордуудыг түшиглэн төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт барьж байгуулах төслийн ТЭЗҮ, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж, байгуулж эхэлнэ.	2013-2014	ҮХААЯ	УУЯ ЭХЯ СЯ ЭЗХЯ		1.6 сая ам.доллар Гадаад эх үүсвэр	Бүтээн байгуулалт эхэлсэн байна.
		2	Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг шинэчилж, хүдэр баяжуулах үйлдвэрт цас, борооны усыг ашиглах судалгаа болон усны нэмэлт эх үүсвэрийг тогтоох хайгуул хийж, зураг төсөл боловсруулна.	2014-2016	ҮХААЯ	БОНХЯ СЯ		800.0 Улсын төсөв	Усны нэмэгдэл эх үүсвэрийг тогтоож, зураг төслийг боловсруулсан байна.
		3	Монголд хүрээлэн буй орчинд ээлтэй тээврийн хэрэгсэл үйлдвэрлэх хөтөлбөрийг баталж хэрэгжүүлнэ.	2013	ҮХААЯ	ЗТЯ		50.0 Улсын төсөв	Хөтөлбөр батлагдсан байна.
51.	Гадаадын шууд хөрөнгө оруулагчидтай харилцан ашигтай байх зарчмыг баримтлан ажиллах. уул, уурхай, эрчим хүч, газрын тосны салбарт өмнө нь байгуулсан тогтвортой байдлын, хөрөнгө оруулалтын, бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдэд өөрчлөлт оруулах асуудлыг судалж, холбогдох өөрчлөлтүүдийг хөрөнгө оруулагч талтай харилцан тохиролцож хийх	1	Оюутолгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахтай холбогдуулан Улсын Их Хурлын шийдвэрүүд, тус төслийн хэрэгжилтийн явцад гарч байгаа зарим тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор уг ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээнд өөрчлөлт оруулах талаар хөрөнгө оруулагч талтай өмнө нь хийсэн яриа хэлэлцээг үргэлжлүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллана.	2012-2016	ЭЗХЯ	УУЯ СЯ			Гэрээнүүдэд өөрчлөлт оруулсан байна.
		2	Газрын тосны холбогдолтой хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгосны үндсэн дээр өмнө нь байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг шинээр батлагдсан хууль тогтоомжтой нийцүүлэн өөрчлөх арга хэмжээ авна.	2012-2016	ЭЗХЯ	УУЯ СЯ			Гэрээнүүдэд өөрчлөлт оруулсан байна.
		3	Тодорхой зарим ордыг ашиглах талаар хөрөнгө оруулагчтай өмнө нь байгуулсан тогтвортой байдлын гэрээний хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгсний үндсэн дээр хөрөнгө оруулагч талтай яриа хэлэлцээ хийх ажлын хэсэг байгуулан холбогдох өөрчлөлтийг оруулах асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэнэ.	2012-2016	ЭЗХЯ	УУЯ СЯ			Гэрээний хэрэгжилтийг дүгнэн, гэрээнд өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлэсэн байна.

52.	Тавантолгойн орд газрыг төрийн мэдэлд байлгах. Тус орд газрыг ашиглах зорилгоор олборлох үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, компанийг дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах замаар байгуулан ажиллуулна. Улмаар Тавантолгойн орд газрыг түшиглэн дотоод, гадаадын хөрөнгийн бирж дээр хувьцааг худалдах ажлыг Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу зохион байгуулна.	1	"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцаатай холбоотой УИХ, Засгийн газрын шийдвэрүүдийн биелэлтийг хангаж, холбогдох шийдвэрийн төслийг боловсруулан УИХ-д өргөн мэдүүлнэ.	2012	ЭЗХЯ	СЯ	"Эрдэнэс МГЛ" ХХК		Хуулийн төслийг өргөн мэдүүлсэн байна.
53.	Тусгай зөвшөөрлийн арилжаанд ил тод байдлыг бүрдүүлэх	1	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг цахим үйлчилгээнд бүрэн шилжүүлнэ.	2013	МТШХХГ		ТББ ХХ	300.0 Улсын төсөв	Цахим үйлчилгээнд шилжсэн байна.
54.	Байгаль орчинд ээлтэй, шилдэг техник, технологийг уул уурхайн үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж, эвдрэлд орсон талбайн тооллого хийж буруутай этгээдээр нөхөн сэргээлгэж, цаашид нөхөн сэргээлтийн зардлыг улсын төсвийн тусгай санд байршуулдаг болгох	1	Уурхайн нөхөн сэргээлтийн зардлын барьцааны хөрөнгө тооцох эрх зүйн орчинг шинэчлэн, тусгай санд урьдчилан байршуулах журмыг боловсронгуй болгоно.	2013-2015	БОНХЯ	СЯ УУЯ			Уурхайн нөхөн сэргээлтэд хангалттай хүрэлцэх хөрөнгийг урьдчилан байршуулдаг болсон байна.
		2	Эвдрэлд орж эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх санхүүжилтийн асуудлын эрх зүйн орчныг бий болгож, нөхөн сэргээлт хийсэн газрын мэдээллийн нэгдсэн санг бий болгоно.	2013	БОНХЯ	УУЯ		400.0 Улсын төсөв	Мэдээллийн нэгдсэн сан бий болсон байна.
		3	Байгаль орчны бохирдол, доройтол, байгалийн нөөцийн ашиглалтад тавих хяналтыг эрчимжүүлж, уул уурхайн нөхөн сэргээлтийн хэмжээг 70-аас доошгүй хувьд хүргэнэ.	2012-2016	УУЯ	БОНХЯ МХЕГ			Нөхөн сэргээлтийн хэмжээг 70-аас доошгүй хувьд хүргэсэн байна.
55.	Уул уурхайн салбарын түүхий эдэд нэмүү өртөг шингээх бодлого хэрэгжүүлэн хагас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, экспортолж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг татварын бодлогоор хөхиүлэн дэмжих	1	Уул уурхайн түүхий эд ашиглан нэмүү өртөг шингэсэн хагас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн гадаад, дотоод зах зээлд нийлүүлж байгаа үйлдвэрлэгчдийг татварын бодлогоор дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	2013-2016	ҮХААЯ	УУЯ ЭЗХЯ СЯ ХЗЯ		Эрх зүйн орчин бүрдсэн байна.	
1. Үйлдвэржүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх бодлого									
56.	Уул уурхайн бүтээгдэхүүнийг боловсруулах зорилгоор аж үйлдвэрийн анхны паркийг Дорноговь аймгийн Сайншанд хотод байгуулах	1	Чойрын 220 кВ-ын дэд станцыг өргөтгөнө.	2013-2016	ЭХЯ	УУЯ	ХХ	25.000.0 Улсын төсөв	Дэд станц, шугам ашиглалтад орсон байна.
		2	Чойр-Сайншандын 2 хэлхээт 220 кВ-ын 220 км шугам, дэд станцыг барина.	2013-2016	ЭХЯ	УУЯ	ХХ	80.000.0 Улсын төсөв	
		3	"Сайншанд" аж үйлдвэрийн цогцолборын дэд бүтэц, үйлдвэрийн ТЭЗҮ-г нарийвчлан боловсруулж батална.	2013-2015	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ БХБЯ ЗТЯ ЭХЯ		26.100.0 Улсын төсөв	ТЭЗҮ батлагдсан байна.

		4	“Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батална.	2013	ҮХААЯ	ЭЗХЯ СЯ УУЯ БХБЯ	Дорноговь АЗД	1.000.0 Улсын төсөв	Ерөнхий төлөвлөгөөг баталсан байна.
		5	“Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборын газар доорх болон гадаргын усны эх үүсвэрийн гидрогеологийн эрэл, хайгуул судалгааг явуулж, ус хангамжийн эх үүсвэрүүдийг тогтоон нөөцийг тодорхойлон, үерийн ус, цас борооны ус ашиглан усны эх үүсвэрийг нэмэгдүүлэх технологийг нэвтрүүлэх, зураг төсөл боловсруулах, бохир усыг эргүүлэн ашиглах технологийг судалж дүгнэлт гаргана.	2013	ҮХААЯ	БОНХЯ СЯ		4.900.0 Улсын төсөв	Нөөцийг тодорхойлон, үйлдвэрийн усны хэрэглээг нарийвчлан тогтоосон байна.
		6	“Сайншанд” аж үйлдвэрийн цогцолбор төслийн мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх, өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах төрийн өмчит үйлдвэрийн газрыг байгуулна.	2012-2013	ҮХААЯ	ХЗЯ СЯ		70.000.0 Улсын төсөв	Төрийн өмчит үйлдвэрийн газрыг байгуулсан байна.
		7	“Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг эдийн засаг, татварын бодлогоор дэмжих эрх зүйн таатай орчныг бүрдүүлнэ.	2012-2016	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ		20.0 Улсын төсөв	Эрх зүйн орчин бүрдсэн байна.
		8	“Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборын дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний байгууламжийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэнэ.	2013-2016	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ БХБЯ ЗТЯ ЭХЯ		3.700.0 сая ам.доллар	Дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний байгууламжийн хөрөнгө орруулалт шийдвэрлэгдсэн байна.
		9	“Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборын мастер төлөвлөгөөнд тусгагдсан үйлдвэрийг хувийн хэвшлийн үүсгэл санаачлагад тулгуурлан байгуулж эхэлнэ.	2014-2016	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ БХБЯ ЗТЯ ЭХЯ		5.947.000.0	Кокс, цемент, зэс хайлуулах, төмрийн хүдрийн үйлдвэр байгуулж эхэлсэн байна.
		10	“Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборын хүрээнд бетон зуурмагийн үйлдвэр байгуулна.	2014	БХБЯ	ЭЗХЯ ҮХААЯ	Дорноговь АЗД ХХ	840.0 ХХО	Үйлдвэр байгуулагдсан байна.
		11	“Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборыг дагаж хөгжих хөнгөн үйлдвэрийг байгуулж эхэлнэ.	2012-2014	ҮХААЯ	ЭЗХЯ СЯ		12.000.0	Үйлдвэр байгуулж эхэлсэн байна.
57.	Дархан хотын төмөрлөгийн үйлдвэрийг шинэчилж, хүдэр баяжуулдаг болох	1	Дарханы төмөрлөгийн үйлдвэрт технологийн шинэчлэл хийж, хүдэр баяжуулдаг болно.	2013	ҮХААЯ	УУЯ	“ДТҮ” ТӨХК		Жилд 165.0 мянган тонн ган цувимал үйлдвэрлэх боломжтой болсон байна.

		2	Төмөртэй, Хуст уулын төмрийн хүдрийн ордыг түшиглэн нойтон баяжуулах үйлдвэр барьж эхэлнэ.	2013-2014	ҮХААЯ	УУЯ		1.6 сая ам.доллар Гадаад эх үүсвэр	Үйлдвэр байгуулж эхэлсэн байна.	
58.	“Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүс, “Алтанбулаг” болон “Цагааннуур” худалдааны чөлөөт бүсүүдийн дэд бүтцийг цогцоор нь барьж дуусгах	1	Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	2012-2014	БХБЯ	СЯ	Дорноговь АЗД	1.360.0 сая ам.доллар БНХАУ-ын хөнгөлөлттэй зээл	Замын-Үүдийн дэд бүтэц сайжирсан байна.	
		2	Алтанбулаг, Замын-Үүд, Цагааннуурын чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулна.	2012-2014	ЭЗХЯ	БХБЯ ЭХЯ СЯ	Холбогдох АЗД	Улсын төсөв	Ерөнхий төлөвлөгөө батлагдсан байна.	
		3	“Алтанбулаг” болон “Цагааннуур” худалдааны чөлөөт бүсүүдийн дэд бүтцийг үе шаттайгаар барина.	2013-2016	ЭЗХЯ	ЗТЯ БХБЯ ЭХЯ СЯ	АЗД	40.000.0 Улсын төсөв Бусад	Бүсүүдийн дэд бүтцийг байгуулсан байна.	
59.	“Чойр”, “Багахангай” ложистик төвийн эхний ээлжийн дэд бүтцийг барьж байгуулах	1	“Чойр”, “Багахангай” ложистик төвийн эхний ээлжийн дэд бүтцийг улсын төсвийн хөрөнгө оруулалт болон концессын гэрээгээр барьж байгуулна.	2013-2014	ЭЗХЯ			Концессын гэрээ	Ложистик төвийн эхний ээлжийн дэд бүтцийг байгуулсан байна.	
60.	Уул уурхайн бус экспортыг дэмжих, хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хувийн хэвшлийн оролцоо, манлайлалтай боловсруулан хэрэгжүүлэх. Уул уурхайн салбарын экспортын орлогын тодорхой хэсгээс уул уурхайн бус экспортын хөгжлийн сан байгуулах	1	Уул уурхайн бус экспортыг дэмжих, хөгжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	2013-2016	ЭЗХЯ	ҮХААЯ			Хөтөлбөр батлагдсан байна.	
		2	Уул уурхайн салбарын экспортын орлогоос хуримтлал үүсгэн, уул уурхайн бус экспортын хөгжлийг дэмжих Инновацийн сан байгуулж, өндөр болон ногоон технологи, сэргээгдэх эрчим хүч зэрэг чиглэлээр дэвшилтэт технологийг нэвтрүүлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортлох компаниудад санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.	2013-2016	ЭЗХЯ	СЯ УУЯ ҮХААЯ			Сан байгуулагдсан байна.	
		3	Жижиг, дунд үйлдвэрийн салбарт оюуны өмчийн тогтолцоог ашиглах санхүүгийн хөшүүргийг бий болгож дэмжлэг үзүүлнэ.	2013-2014	ЭЗХЯ	ОӨГ			6.000.0 Улсын төсөв	Оюуны өмч, шинэ технологи, инновацид түшиглэсэн ЖДҮ-үүд бий болсон байна.
		4	Биет бус хөрөнгө болон оюуны өмчийн үнэлгээний тогтолцоог бүрдүүлж бизнесийн үйл ажиллагаанд нэвтрүүлж хэвшүүлнэ.	2014	ЭЗХЯ	ОӨГ			10.000.0 Улсын төсөв	Оюуны өмч, шинэ технологи, инновацид түшиглэсэн ЖДҮ-үүд бий болсон байна.
61.	Дэлхийн худалдааны байгууллагад элсэхдээ хүлээсэн үүргийн дагуу гааль, тарифын	1	Импортын гаалийн тарифын ерөнхий түвшин 20 хувь байх зарчмыг баримтална.	2013-2016	СЯ				Тарифыг одоогийн	

	механизмыг ашиглан үндэсний үйлдвэрлэлээ хамгаалах асуудлыг шийдвэрлэх								түвшинд байлгасан байна.
		2	Экспорт, импортын бараанд нэр төрөл, бүс нутаг, үйлдвэрлэгчээр ялгавартай тариф тогтооно.	2013-2016	СЯ				Тарифыг ялгавартай тогтоосон байна.
		3	Импортын буудай, гурил, хүнсний ногооны гаалийн албан татварын хувь хэмжээг ДХБ-ын гэрээ хэлэлцээрийн хүрээнд нэмнэ.	2013-2014	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ			Татвар нэмэгдсэн байна.
62.	Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж, цемент, төмөр хийц, шил, дулаалгын материал зэрэг бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах бодлого баримтлах	1	Хөтөлийн “Цемент шохой” ХК-ийн үйлдвэрийн өргөтгөлийг дуусгаж, хүчин чадлыг жилд 1.0 сая тонноор нэмэгдүүлнэ.	2013	БХБЯ	ЭЗХЯ	Сэлэнгэ АЗД ХК	73.500.0 ХБ	Хүчин чадлыг жилд 1.0 сая тоннд хүргэсэн байна.
		2	Дорноговь аймгийн Даланжаргалан суманд шохойн чулууны ордод түшиглэн жилд 1.0 сая тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр байгуулахыг дэмжинэ.	2013-2015	БХБЯ	ЭЗХЯ	Дорноговь АЗД ХХ	210.000.0 ХБ ХХ	Үйлдвэр байгуулагдсан байна.
		3	Ховд аймагт жилд 100.0-200.0 мянган тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр барихыг дэмжинэ.	2013-2016	БХБЯ	ЭЗХЯ	Ховд АЗД ХХ	6.615.0 ХБ ХХ	Үйлдвэр байгуулагдсан байна.
		4	Дархан-Уул аймагт арматур, төмөр хийцийн үйлдвэр байгуулна.	2013-2015	БХБЯ	ЭЗХЯ	Дархан-Уул АЗД ХХ	1.400.0 ХБ ХХ	Үйлдвэр байгуулагдсан байна.
		5	Хаягдал шилийг ашиглаж бетон дүүргэгч шилэн блокны үйлдвэр байгуулна.	2013-2016	БХБЯ	ЭЗХЯ	ХХ	5.000.0 ХБ ХХ	Үйлдвэр байгуулагдсан байна.
		6	Дулаан тусгаарлах материалын үйлдвэрлэлийг дэмжиж, хөнгөн дүүргэгч, хөнгөн бетон, эрдэс хөвөн, хонины ноосон дулаалгын материалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг 100 хувь хангана.	2013-2016	БХБЯ	ЭЗХЯ	АЗД ХХ	28.000.0 ХБ ХХ	Дотоодын хэрэгцээг 100 хувь хангадаг болсон байна.
		7	Бүс нутгийн барилгын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Хөвсгөл, Дорнод, Өмнөговь аймагт цементийн үйлдвэр барих судалгаа хийнэ.	2013-2016	БХБЯ	ЭЗХЯ	Холбогдох АЗД	1.000.0	Судалгаа хийгдсэн байна.
63.	Сэргээгдэх эрчим хүчний бодлогыг татварын орчноор хөхиүлэн дэмжиж гадаад, дотоодын хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт орж ирэх таатай нөхцөлийг бүрдүүлэх	1	Сэргээгдэх эрчим хүчийг татварын орчноор дэмжих чиглэлээр холбогдох хуулийн төсөл боловсруулна.	2012-2014	ЭХЯ	ЭЗХЯ СЯ ХЗЯ	СЭХҮТ	100.0	Гадаад, дотоодын хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт орж ирэх нөхцөл бүрдсэн байна.
		2	Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний нөөцийн судалгаа хийнэ.	2012-2016	ЭХЯ	ЭЗХЯ СЯ	СЭХҮТ	1.000.0 Улсын төсөв 5.000.0 Гадаадын зээл	Судалгааг хийсэн байна.

		3	Сэлэнгэ мөрний ай сав газарт том чадлын УЦС барих судалгаа, ТЭЗҮ боловсруулах ажлыг эхлүүлнэ.	2012-2013	ЭХЯ	ЭЗХЯ СЯ	ХХ	Гадаад орны зээл	300 МВт-ын хүчин чадалтай УЦС-ыг барих нөхцөл бүрдсэн байна.
		4	Монгол орны нөхцөлд нарны дулааны цахилгаан станц байгуулах боломжийн талаар судалгаа хийнэ.	2012-2016	ЭХЯ	ЭЗХЯ СЯ		1.500.0 Улсын төсөв Зээл, тусламж	Судалгаа хийгдсэн байна.
64.	Эдийн засгийн өсөлтийг хангахуйц эрчим хүчний суурь дэд бүтцийг бий болгох зорилгоор ДЦС-5-ыг барьж, ДЦС-4-ийг 100 МВт-р өргөтгөх	1	"ДЦС-5"-ыг барьж ашиглалтад оруулна.	2012-2016	ЭХЯ	ЭЗХЯ ҮХААЯ ЗТЯ БОНХЯ	НЗД ХХ ГХО	1.500.000.0 Концессын гэрээ	Цахилгаан станц ашиглалтад орсон байна.
		2	"ДЦС-5"-аас дэд станцууд хүртэл 110-220 кВ шугам татаж, дэд станцыг өргөтгөнө.	2013-2015	ЭХЯ	ЭХЗЯ СЯ		41.200.0 Улсын төсөв	Шугам, дэд станц ашиглалтад орсон байна.
		3	"ДЦС-5"-ын дулаан дамжуулах магистраль шугамуудыг шинэчлэн өргөтгөнө.	2013-2015	ЭХЯ	ЭХЗЯ СЯ		30.000.0 Улсын төсөв	Магистраль шугамуудын нэвтрүүлэх чадвар нэмэгдсэн байна
		4	"ДЦС-4"-ын хүчин чадлыг 100 МВт-аар нэмэгдүүлнэ.	2012-2014	ЭХЯ	ЭЗХЯ СЯ		140.000.0 ХБ	Хүчин чадал 100 МВт-аар нэмэгдсэн байна.
65.	Баруун бүсийн нүүрсний ордуудыг түшиглэн 60-100 МВт-ын дунд чадлын цахилгаан станц барих	1	Баруун бүсийн нүүрсний ордуудыг түшиглэн ДЦС барих ажлыг эхлүүлнэ.	2012-2015	ЭХЯ	ЭЗХЯ СЯ		160.000.0 Гадаадын зээл	Цахилгаан станц ашиглалтад орсон байна.
66.	Улаанбаатар хотын цахилгаан, дулааныг дамжуулах дэд бүтцийг шинэчлэх	1	Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн халаалтын зуух "УС 15"-ыг өргөтгөн 250 Гкал/цаг чадалтай дулааны станц барина.	2012-2014	ЭХЯ	ЭЗХЯ СЯ	НЗД	90.000.0 ХБ	Цахилгаан станц ашиглалтад орсон байна.
		2	"ДЦС-4"-ын дулаан дамжуулах 10 дугаар магистраль шугамын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлнэ.	2012-2015	ЭХЯ	ЭЗХЯ СЯ		7.600.0 Улсын төсөв	Магистраль шугамын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлсэн байна.
		3	Улаанбаатар хотын цахилгаан дамжуулах "Их тойрог" сүлжээ, 220 кВ-ийн дэд станцыг барьж дуусгана.	2012-2014	ЭХЯ	ЭЗХЯ СЯ		67.000.0 Улсын төсөв	Сүлжээ, дэд станцыг барьж дуусгасан байна.
		4	Гэр хорооллын 113 байршилд 33 ширхэг АТП /агаарын дэд станц/ шинээр барьж, 103 АТП-д өргөтгөл хийж 0,4-10, кВ-ын 250 км шугам татах, Улаанбаатар хотын 100 км 6-10 кВ-ын кабель шугамын өргөтгөл, шинэчлэх ажлыг хийнэ.	2013-2016	ЭХЯ	ЭЗХЯ СЯ	НЗД	75.000.0 Улсын төсөв Гадаадын зээл	АТП, шугамыг барьж дуусгасан байна.
67.	Дотоодын эрчим хүчний хэрэгцээг бүрэн хангаж, эрчим хүч экспортлогч улс болох	1	Эрчим хүчний 2013-2020 хүртэлх мастер төлөвлөгөө болон эрчим хүчний талаар	2013	ЭХЯ	ЭЗХЯ СЯ		1.600.0 Буцалтгүй	Бодлогын баримт

			төрөөс баримтлах бодлогын баримт бичгийг шинээр, "Эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр"-ийг шинэчлэн боловсруулж батлуулна.					тусламж	бичгүүдийг батлуулсан байна.
	2	Дорнод бүсийн эрчим хүчний системийн хүчин чадлыг нэмэгдүүлж 100 МВт-ын шинэ ДЦС барина.	2013-2014	ЭЗХЯ	ЭХЯ			200.000.0 Концессын гэрээ	Шинэ ДЦС барьсан байна.
	3	Тавантолгойн нүүрсний ордыг түшиглэн 300 МВт-ын ДЦС-ыг барьж байгуулна.	2012-2016	ЭХЯ	ЭЗХЯ СЯ	XX		840.000.0 ХО	Хөрөнгө оруулагч станцыг ашиглалтад оруулсан байна.
	4	Оюутолгойн 450 МВт-ын ДЦС-ыг барьж байгуулна.	2012-2016	ЭХЯ	ЭЗХЯ СЯ	XX		1.240.000.0 ХО	Хөрөнгө оруулагч станцыг ашиглалтад оруулсан байна.
	5	Нялга-Чойрын бүсийн нүүрсний сав газарт 300 МВт-ын том чадлын цахилгааны эх үүсвэрийг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.	2012-2016	ЭХЯ	ЭЗХЯ СЯ			700.000.0 ХО	Хөрөнгө оруулагч станцыг ашиглалтад оруулсан байна.
	6	Баянтээгийн 40 МВт-ын ДЦС-ын ТЭЗҮ-ийг боловсруулж барина.	2013-2016	ЭХЯ	ЭЗХЯ СЯ			120.000.0 Гадаадын зээл	Цахилгаан станцыг ашиглалтад оруулсан байна.
	7	Дарханы ДЦС-ын хүчин чадлыг 30 МВт-аар нэмэгдүүлнэ.	2012-2015	ЭХЯ	ЭЗХЯ СЯ			19.000.0 Улсын төсөв	Дарханы ДЦС-д 30 МВт-чадалтай турбин нэмж суурилуулсан байна.
	8	Эрдэнэтийн ДЦС-ын хүчин чадлыг 30 МВт-аар нэмэгдүүлнэ	2012-2015	ЭХЯ	ЭЗХЯ СЯ			19.000.0 Улсын төсөв	Эрдэнэтийн ДЦС-д 30 МВт-чадалтай турбин нэмж суурилуулсан байна.
	9	ДЦС-3-ын 9 дүгээр зуухыг сэргээн босгоно.	2013-2014	ЭХЯ	ЭЗХЯ СЯ			11400 Улсын төсөв	ДЦС-3-ын №9 зуух ашиглалтад орсон байна.
	10	Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг өргөтгөж, шинэчлэх төсөл хэрэгжүүлнэ.	2012-2014	ЭХЯ	ЭЗХЯ СЯ			310.000.0 Гадаадын зээл	ДЦС-5 болон төвийн бүсийн дулааны цахилгаан станцуудыг нүүрсээр бүрэн хангадаг болсон байна.
	11	УБ-Мандалговийн 330 кВ-ын 2 хэлхээт ЦДАШ, дэд станцыг барина.	2013-2016	ЭХЯ	ЭЗХЯ СЯ			100.000.0 Улсын төсөв	ЦДАШ, дэд станц ашиглалтад орсон байна.

		12	Багануур-Өндөрхаан-Чойбалсангийн 220 кВ-ын ЦДАШ, дэд станцыг барина.	2013-2014	ЭХЯ	ЭЗХЯ СЯ		150.000.0 Улсын төсөв Концессын гэрээ	ЦДАШ, дэд станц ашиглалтад орсон байна.
		13	Эрчим хүчний шинэ эх үүсвэр барих асуудлыг эрчимжүүлж дотоодын эрчим хүчний хэрэгцээг бүрэн хангахын зэрэгцээ эрчим хүч экспортлох бэлтгэл ажлыг хангаж, энэ талаар хууль эрх зүйн орчинг бүрдүүлнэ.	2012-2016	ЭХЯ	ЭЗХЯ ХЗЯ			Эрх зүйн орчин бүрдсэн байна.
2. Ноос, ноолуур, арьс ширний чиглэлээр хэрэгжүүлэх бодлого									
68.	Ноолуурын салбарын зээлийн санг 300 тэрбум, арьс ширний салбарын зээлийн санг 300 тэрбум, ноосны салбарын зээлийн санг 50 тэрбум, махны үйлдвэрлэлийг дэмжих зээлийн санг 100 тэрбум төгрөгт хүргэх	1	Ноолуур, арьс шир, ноос, махны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд зориулсан зээлийн сан байгуулах эх үүсвэрийг тодорхойлон, үйлдвэрлэл эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	2012-2013	ҮХААЯ	ЭЗХЯ СЯ			Зээлийн сангийн хэмжээ нэмэгдсэн байна.
		2	Мал, мах бэлтгэн нийлүүлэгч компаниудад эргэлтийн хөрөнгийн зээл олгоно.	2013	ҮХААЯ	ЭЗХЯ СЯ			Нийт 25.4 мян.тн мах зах зээлд нийлүүлж, нийслэлийн хүн амын махны хэрэгцээний 23 хувийг хангадаг болсон байна.
69.	Малын гаралтай түүхий эд, ноолуур, ноос, арьс ширийг боловсруулж, зах зээлд нийлүүлдэг болох	1	Ноолуур, ноолууран бүтээгдэхүүний олон улсын чанарын баталгаажуулалтын лаборатори байгуулна.	2012-2014	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ		10.000.0 Улсын төсөв	Лаборатори байгуулсан байна.
		2	Боловсруулах үйлдвэрт хонь, тэмээний ноос тушаасан малчдад урамшуулал олгодог болно.	2012-2014	ҮХААЯ			120.000.0 Улсын төсөв	80 хувийг дотоодын үйлдвэрт боловсруулдаг болсон байна.
		3	Арьс ширний анхан шатны тордолтын цехийг мал нядалгааны цэгүүдийг түшиглэн байгуулж, арьс ширэн эдлэлийн үйлдвэрийг аймаг, бүсүүдэд хөгжүүлэхэд зээлийн дэмжлэг үзүүлнэ.	2012-2014	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ		75.000.0 Улсын төсөв	Үйлдвэрүүд байгуулагдсан байна.
		4	Үйлдвэрийн хаягдлыг боловсруулан шахмал шир, шингэн саван, желатины үйлдвэр тус бүр 1-ийг Үйлдвэрлэл, технологийн паркийн бүсэд байгуулна.	2012-2014	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ		3.000.0 Улсын төсөв	Үйлдвэрүүд байгуулагдсан байна.
70.	Дархан-Уул аймаг, Улаанбаатар хотын гадна байгаль орчинд ээлтэй, хаягдлаа бүрэн боловсруулах чадвартай арьс шир боловсруулах үйлдвэр байгуулахыг дэмжих	1	Улаанбаатар, Дархан хотын гадна талд арьс ширний үйлдвэрийн цогцолбор байгуулах дэд бүтцийг барьж эхэлнэ.	2012-2014	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ БШУЯ		450.000.0 Улсын төсөв	Дэд бүтцийг барьж эхэлсэн байна.
		2	Улаанбаатар хотын төвийн дүүргээс арьс шир боловсруулах, ноос, ноолуур угаах үйлдвэрүүдийг нүүлгэх арга хэмжээ авна.	2012-2016	НЗД	ҮХААЯ			Үйлдвэрүүдийг нүүлгэсэн байна.

		3	Орчин үеийн цөмийн технологи ашиглан хаягдал усыг цэвэршүүлэх, ариутгах, дахин ашиглах нөхцөлийг бүрдүүлэх	2012-2016	ЦЭГ		НЗД Арьс ширний үйлдвэр		Хаягдал усыг дахин ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн байна.
3. Уламжлалт мал аж ахуй, мах, сүүний чиглэлээр хэрэгжүүлэх бодлого									
71.	Малын индексжүүлсэн даатгалыг давхар даатгалд хамруулах замаар олон улсын стандартын дагуу мал сүргийг бүртгэж даатгах	1	Малын даатгалын системийг боловсронгуй болгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	2013-2016	СЯ	ҮХААЯ ХЗЯ	ОУБ-ын төсөл ТББ		Эрх зүйн орчин бүрдсэн байна
		2	Малын индексжүүлсэн даатгал төслийг орон даяар хэрэгжүүлж, нийт малчин өрхийн 15-аас доошгүй хувьд даатгалын үйлчилгээ хүргэнэ.	2012-2016	СЯ	ҮХААЯ СЗХ		10.0 сая ам.доллар ДБ-ны хөнгөлөлттэй зээл	Нийт малчин өрхийн 15-аас доошгүй хувийг даатгалд хамруулсан байна.
		3	Малын индексжүүлсэн даатгалын төслийн хүрээнд зарим аймгуудын даатгагдсан малыг давхар даатгалын тогтолцоонд шилжүүлэх арга хэмжээ авна.	2012-2016	СЗХ	СЯ		300.000	Тогтолцоонд шилжсэн байна.
72.	Хангайн бүсийн аймгуудад өндөр ашиг шимт мах, сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуй, говь хээрийн бүсэд өндөр ашиг шимт хонь, ямааны аж ахуйг дэмжиж, тариалангийн бүс нутагт дэвшилтэт технологи бүхий фермерийн аж ахуйг хөгжүүлэх	1	Хангайн, баруун, зүүн бүсийн аймгуудад махны чиглэлийн үхрийн цогцолбор аж ахуй байгуулна.	2013-2016	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ		72.000.0 Улсын төсөв ХХ	8000-аас доошгүй үхрийг үржүүлж эхэлсэн байна.
		2	Нийслэл болон томоохон хот суурингийн ойролцоо сүүний чиглэлийн үхрийн цогцолбор аж ахуй хөгжүүлнэ.	2013-2016	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ		18.000.0 Улсын төсөв	Цогцолбор аж ахуй байгуулагдсан байна.
		3	Улаанбаатар хотыг эрүүл, экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүнээр тогтвортой хангах зорилгоор “Стратегийн хүнсний биотехнологийн үйлдвэрлэл, хөгжлийн загвар бүс” төслийг хэрэгжүүлнэ.	2012-2016	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ БШУЯ	ХААИС		Төслийг хэрэгжүүлсэн байна.
		4	Говь, хээрийн бүсийн аймгуудад махны чиглэлийн хонь бордох цогцолбор аж ахуйнууд байгуулна.	2013-2016	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ		4.5000.0 Улсын төсөв	Нийт махны хэрэгцээний 1.5-аас доошгүй хувийг хангадаг болсон байна.
		5	Тариалангийн бүс нутаг дахь эрчимжсэн аж ахуйн тоо, бүтээмжийг нэмэгдүүлнэ.	2013-2016	ҮХААЯ		АЗД	20.000.0 Улсын төсөв	Эрчимжсэн аж ахуйн тоо, бүтээмж нэмэгдсэн байна.
		6	Цогцолбор аж ахуйг түшиглэн малын тэжээлийн үйлдвэр, цех шинээр барьж байгуулна.	2013-2016	ҮХААЯ		АЗД	10.000.0 Улсын төсөв	Тэжээлийн үйлдвэр, цех байгуулагдсан байна.
73.	Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, зах зээлд нийлүүлэх зорилго бүхий хөдөө аж ахуйн биржийг байгуулах	1	Нийслэл болон аймаг, сумдад хөдөө аж ахуйн биржийн сүлжээ байгуулна.	2013-2016	ҮХААЯ		АЗД	1.000.0 Улсын төсөв	Биржүүд байгуулагдсан байна.

		2	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийг бий болгоно.	2013-2015	МТШХХГ	ҮХААЯ	ХХ	2.000.0 Улсын төсөв	Бүртгэл, мэдээллийн нэгдсэн системтэй болсон байна.
		3	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний цахим биржийг байгуулна.	2013-2014	ҮХААЯ	МТШХХГ	ХХ	700.0 Улсын төсөв	Цахим биржийг байгуулсан байна.
74.	Сумын хөгжлийн сангийн эх үүсвэрийг 150 саяаас доошгүй, аймаг, дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих санг 3 тэрбумаас доошгүй, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн эх үүсвэрийг 500 тэрбумаас доошгүй төгрөгийн эх үүсвэртэй байгуулах	1	Жил бүрийн улсын төсөвт эх үүсвэрийг тусган хуваарилж, эх үүсвэрийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмыг боловсруулан мөрдөнө.	2012-2016	ХЯ	СЯ	АНЗД	662.000.0 Улсын төсөв	Журам батлагдсан байна.
75.	Эрчимжсэн мал аж ахуй, гахай, шувууны аж ахуй эрхэлж байгаа аж ахуйг дэмжих зээлийн санг 50 тэрбумаас доошгүй төгрөгийн эх үүсвэртэй байгуулах	1	Мал хамгаалах санд эрчимжсэн аж ахуйг дэмжих зээлийн эргэлтийн сан бий болгох эрх зүйн орчинг бүрдүүлж, зээл олгоно.	2013-2016	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ			Сангийн хэмжээ 50.0 тэрбум төгрөгт хүрсэн байна
		2	Сүүний чиглэлийн үхрийн аж ахуйг хөгжүүлэхэд зээлийн дэмжлэг үзүүлнэ.	2013-2016	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ		20.000.0 Улсын төсөв	Импортын сүүний 30.0 хувийг хангадаг болсон байна.
		3	Тариалангийн бүсэд гахайн цогцолбор аж ахуй хөгжүүлэхэд зээлийн дэмжлэг үзүүлж, гахайн мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	2013-2016	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ		10.000.0 Улсын төсөв	Импортын гахайн махны 25.0 хувийг хангадаг болсон байна.
		4	Хот суурингийн ойролцоо шувууны аж ахуйг хөгжүүлэхэд зээлийн дэмжлэг үзүүлж, өндөгний хэрэгцээг бүрэн хангана.	2013-2016	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ		20.000.0 Улсын төсөв	Өндөгний хэрэгцээг бүрэн хангадаг болсон байна.
76.	Газар тариалан, фермерийн бүс нутгийг түшиглэн хуурай сүү боловсруулах үйлдвэр, аймгуудад цөцгийн тос болон сүүн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахыг дэмжих	1	Хоногт 30 тн сүү боловсруулах хүчин чадалтай хуурай сүүний үйлдвэр байгуулна.	2013-2016	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ		30.000.0 БНХАУ-ын зээл	Хуурай сүүний импортыг 20 хувь бууруулсан байна.
		2	Баруун болон төвийн бүсийн аймгуудад хоногт 1 тонноос доошгүй сүү боловсруулах хүчин чадалтай үйлдвэр байгуулахад хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлнэ.	2013-2014	ҮХААЯ		АЗД	1.200.0 Улсын төсөв	Үйлдвэр байгуулагдсан байна.
77.	Мах, махан бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах зорилгоор махны нийлүүлэлтийн шинэ тогтолцоог бүрдүүлэх	1	Мал нядалгааны үйлдвэр, цехэд 3-7 дугаар сард мал нийлүүлсэн малчдад урамшуулал олгоно.	2013-2015	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ	АЗД	75.000.0 Улсын төсөв	Өвөл, хаврын улиралд нийлүүлж буй махны хэмжээ өссөн байна.
		2	Махны эрэлт нийлүүлэлтийг харгалзан экспорт, импортын зохицуулалтын арга хэмжээг авна.	2013	ҮХААЯ	ЭЗХЯ	МХЕГ		Махны нийлүүлэлт 4.8 хувиар нэмэгдсэн байна.
		3	Биржээр малын худалдаа зохион байгуулах ажлыг сум бүрт туршилтын журмаар зохион	2014-2015	ҮХААЯ	ЭЗХЯ	АЗД	2.000.0 Улсын төсөв	Нийт малын 10-30 хувийг

			байгуулна.						биржээр борлуулсан байна.
		4	Хөргөлттэй агуулах, лангуу, тоног төхөөрөмж бүхий махны төрөлжсөн зах байгуулахад хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлнэ.	2013-2015	ҮХААЯ	ШӨХТГ	НЗД	5.000.0 Улсын төсөв	Захуудыг байгуулж, зээл олгосон байна.
		5	Улаанбаатар хот болон загасны нөөцтэй аймгуудад загас боловсруулах үйлдвэр байгуулна.	2013-2015	ҮХААЯ	БОНХЯ ХЯ		5.000.0 Улсын төсөв	5 үйлдвэр, цех байгуулагдсан байна.
78.	“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, мал эмнэлэг, үржлийн төрийн үйлчилгээний албыг бүх суманд бэхжүүлэх	1	Мал аж ахуйн үйлдвэрлэлд бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийг бий болгож, мал, түүний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг баталгаажуулдаг болно.	2012-2016	ҮХААЯ		АЗД	8.000.0 Улсын төсөв	Гарал үүслийг баталгаажуулдаг болсон байна.
		2	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, зорилтот зах зээлийг хөгжүүлнэ.	2012-2016	ҮХААЯ	ЭЗХЯ СЯ	АЗД ТББ	24.000.0 Улсын төсөв	Үйлдвэрлэлийн бүтээмж, өрсөлдөх чадвар дээшилсэн байна.
		3	Малын удмын сангийн үндэсний цогцолбор байгуулж, малын генетик нөөцийг хамгаалах, ашиглах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх арга хэмжээ хэрэгжүүлнэ.	2013-2016	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ	АЗД МУСҮТ	43.200.0 Улсын төсөв	Цогцолбор байгуулсан байна.
		4	Мал аж ахуйн хөгжил, малын генетик нөөц, малын эрүүл мэндийн талаар хуулийн төсөл боловсруулна.	2013-2014	ҮХААЯ	ХЗЯ БОНХЯ			Хуулийн төслийг өргөн мэдүүлсэн байна.
		5	Малын үржлийн үйлчилгээний нэгжийн хүртээмжийг нэмэгдүүлж, гойд ашиг шимт мал, үр импортоор оруулж, үржлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болно.	2014-2016	ҮХААЯ			80.000.0 Улсын төсөв	Үржлийн үйлчилгээний нэгжийн тоо өсч, үржлийн бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэдэг болсон байна.
		6	Бэлчээр, тэжээл, усан хангамжийг зохистой ашиглах, хамгаалах менежментийн цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2012-2016	ҮХААЯ	БОНХЯ	АЗД	80.000.0 Улсын төсөв	Малын тэжээл, усан хангамж сайжирсан байна.
		7	Малын эрүүл мэнд, хорио цээрийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, мал эмнэлгийн албаны үндэсний тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн, малын гаралтай бүтээгдэхүүнийг экспортлох нөхцөлийг бүрдүүлнэ.	2012-2016	ҮХААЯ	МХЕГ	МҮМЭХ		Малын гаралтай бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэн байна.
		8	Малын гоц халдварт, халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх, эрүүлжүүлэх ажлын бэлэн байдлын чадавхийг дээшлүүлж, гоц	2011-2016	ҮХААЯ	МХЕГ	УМЭАЦТЛ	78.500.0 Улсын төсөв	Статус хангагдсан байна.

			халдварт өвчнөөр тайван орны статус хангана.						
		9	Улсын хилээр мал, амьтны халдварт өвчин нэвтрэх, дотоодод дамжин тархах эрсдэлийг тогтвортой бууруулах нөхцөлийг бүрдүүлнэ.	2012-2016	ҮХААЯ	МХЕГ	МЭҮТ	81.000.0 Улсын төсөв	Хилээр дамжин орж ирэх эрсдэл буурсан байна.
4. Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх бодлого									
79.	Аялал жуулчлалын салбарын бодлогыг тогтвортой хөгжлийн зарчимд нийцсэн жуулчлалын төрлүүд, түүний дотор тусгай сонирхлын, байгалийн, соёлын аялал жуулчлалыг бүс нутгаар төрөлжүүлэн хөгжүүлэх	1	Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.	2013-2014	ССАЖЯ		ТББ		Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
		2	"Аялал жуулчлалын үндэсний хөтөлбөр"-ийг батлан хэрэгжүүлнэ.	2013-2014	ССАЖЯ	ЭЗХЯ	ТББ		Хөтөлбөр батлагдсан байна.
		3	Аялал жуулчлалын салбарын гадаад сурталчилгааны маркетинг төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.	2013-2016	ССАЖЯ	ГХЯ		21.000.0 Улсын төсөв	Төлөвлөгөө батлагдан хэрэгжиж эхэлсэн байна.
		4	Орон нутагт тусгай сонирхлын, байгалийн, соёлын аялал жуулчлалыг төрөлжүүлэн хөгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	2014-2015	ССАЖЯ	ЭЗХЯ	АНЗД		Хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн байна.
		5	Хүүхэд, залуучуудад зориулсан байгалийн, танин мэдэхүйн болон нүүдлийн соёлын чиглэлээр дотоодын аялал жуулчлалыг дэмжинэ.	2012-2016	ССАЖЯ			500.0	Дотоодын аялал жуулчлал нэмэгдсэн байна.
80.	Монгол Улсын байгалийн үнэт баялаг болсон хангайн бүсэд ашигт малтмал олборлохыг хуулиар хязгаарлаж, байгалийн унаган төрхийг хэвээр хадгалан аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэх	1	Тусгай хамгаалалттай газар, аялал жуулчлалын бүс нутагт ашигт малтмал олборлох зөвшөөрөл олгохыг хориглох эрх зүйн орчин бүрдүүлнэ.	2013-2014	ССАЖЯ	БОНХЯ ХЗЯ	ТББ		Эрх зүйн орчин бүрдсэн байна.
		2	Хөвсгөл аймагт Алунгоо эхийн цогцолбор байгуулна.	2015-2016	ССАЖЯ	ЭЗХЯ	АЗД	3.000.0 Улсын төсөв	Цогцолбор байгуулагдсан байна.
81.	Аялал жуулчлалын дэд бүтэц, барилга, байгууламжийг тухайн нутгийн онцлог, нөөцөд тулгуурлан хөгжүүлэх	1	Аялал жуулчлалын цогцолбор, амралтын газар, жуулчны баазуудын стандартыг шинэчлэн батална.	2013-2014	ССАЖЯ	СХЗГ		30.0 Улсын төсөв	Стандартыг батлан мөрдүүлсэн байна.
		2	Аялал жуулчлалын бүс нутагт шаардлагатай харилцаа холбооны дэд бүтцийг бий болгоно.	2013-2016	МТШХХГ	ССАЖЯ	ОУБ	2.000.0 Улсын төсөв	Дэд бүтэц бий болсон байна.
		3	Улаанбаатар хотын Жуулчны гудамжийг жуулчдад ээлтэй, эрэлтийг нь хангахуйц байдлаар тохижуулна.	2013-2016	ССАЖЯ		НЗД	Улсын төсөв	Гудамжийг тохижуулсан байна.
82.	Аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор зах зээлийн эрэлтэд нийцсэн парк, музей, цогцолборыг төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтарсан хөрөнгө	1	Баруун бүсэд олон ястны соёлын парк байгуулах ажлыг эхлүүлнэ.	2015-2016	ССАЖЯ	БХБЯ	АЗД	5.000.0 Улсын төсөв	Паркийг байгуулж эхэлсэн байна.

	оруулалтаар барьж байгуулахыг дэмжих	2	Хархоринд "XIII зуун" цогцолбор байгуулна.	2013-2016	ССАЖЯ	ЭЗХЯ	АЗД	5.000.0 Улсын төсөв	Цогцолбор байгуулагдсан байна.
		3	Хөвсгөл аймагт цаатан угсаатны музей байгуулна.	2014-2015	ССАЖЯ		АЗД	1.000.0 Улсын төсөв	Музей байгуулагдсан байна.
83.	Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу нийтийн ариун цэврийн газар, иж бүрэн үйлчилгээ бүхий түр буудаллах цэг байгуулахыг дэмжих	1	Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу түр буудаллах цэг байгуулахад хөрөнгө оруулагчдыг дэмжинэ.	2014-2015	ССАЖЯ	СЯ	АЗД	1.000.0 Улсын төсөв ХХ	Түр буудаллах цэгүүд байгуулагдсан байна.
		2	Аялал жуулчлалын бааз, нийтийн үйлчилгээний газруудад бохир усыг цуглуулах, цэвэрлэх технологи бүхий бага оврын цэвэрлэх байгууламжийг нэвтрүүлнэ.	2012-2016	БХБЯ	ССАЖЯ БОНХЯ		15.000.0 Улсын төсөв ХХ	Бага оврын цэвэрлэх байгууламжийг нэвтрүүлсэн байна.
84.	Монгол Улс руу чиглэсэн олон улсын нислэгийн давтамж, чиглэлийг хоёр дахин нэмэгдүүлэх	1	Агаарын харилцааны асуудлаар Засгийн газар хоорондын хэлэлцээрийг шинээр байгуулах, нэмэлт, өөрчлөлт оруулах замаар олон улсын нислэгийн чиглэл, давтамжийг нэмэгдүүлэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлнэ.	2013-2016	ЗТЯ	ГХЯ			Чиглэл 5-аас доошгүй, нислэгийн давтамж 2 дахин нэмэгдсэн байна.
		2	Агаарын хөлгийн парк шинэчлэлтийн төслийг хэрэгжүүлж, Ази, Европын чиглэлийн нислэгийн сүлжээг өргөжүүлнэ.	2013-2016	ЗТЯ	СЯ	ХБ	220.000.0	Өөрийн өмчлөлийн агаарын 3 хөлөгтэй болсон байна.
		3	Европын холбооны улсын нутаг дэвсгэрт агаарын тээвэрлэлтийн 5 дугаар эрх авах зохицуулалтыг түлхүү бүрдүүлж, шинээр Сингапур, БНЭУ руу хуваарьт нислэг гүйцэтгэнэ.	2013-2016	ЗТЯ				Сингапур, Энэтхэг Улс руу хуваарьт нислэг гүйцэтгэдэг болсон байна.
85.	Говийн аялал жуулчлалын бүс, Орхоны хөндийн аялал жуулчлалын бүс, Хөвсгөл нуурын аялал жуулчлалын бүсийг холбосон дэд бүтэц байгуулах	1	Говийн аялал жуулчлалын бүс, Орхоны хөндийн аялал жуулчлалын бүс, Хөвсгөл нуурын аялал жуулчлалын бүсийн хөгжлийн төслийг боловсруулж батална.	2014-2016	БХБЯ	БОНХЯ СЯ ЭЗХЯ	Холбогдох АЗД	1.500.0 Улсын төсөв	Төслүүд батлагдсан байна.
		2	Хархоринг байгаль орчинд ээлтэй хот болгон хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө боловсруулж батална.	2014-2015	БХБЯ	БОНХЯ СЯ ЭЗХЯ	Өвөрхангай АЗД	700.0 Улсын төсөв	Ерөнхий төлөвлөгөөг баталсан байна.
		3	Орхоны хөндий, Хөвсгөл нуурын аялал жуулчлалын бүсэд цахилгаан эрчим хүчний дэд бүтцийг байгуулна.	2014-2016	ЭХЯ	ЭЗХЯ СЯ		15.000.0 Улсын төсөв	Дэд бүтэцтэй болсон байна.
		4	Хужирт-Төвхөн-Улаанцутгалан чиглэлийн 90 км авто замыг барина.	2012-2014	ЗТЯ	ЭЗХЯ		44.600.0	Замыг барьсан байна.
		5	Сайншанд-Хамрын хийд чиглэлийн 42 км хатуу хучилттай авто замыг барина.	2012	ЗТЯ	ЭЗХЯ		17.600.0	Замыг барьсан байна.
		6	Элсэн тасархай-Арвайхээр чиглэлийн 40 км замын хэсэгчилсэн шинэчлэлийн ажлыг хийж дуусгана.	2012-2013	ЗТЯ	ЭЗХЯ		13.900.0	Замыг шинэчилсэн байна.

		7	Мөрөн-Хатгал чиглэлийн 98.8 км хатуу хучилттай авто замыг барьж дуусгана.	2013	ЗТЯ	ЭЗХЯ		19.300.0	Замыг барьсан байна.
		8	Дадал, Хатгал, Хархорины нисэх буудлын үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд сэргээж нислэг үйлдэх боломжийг бүрдүүлнэ.	2013	ЗТЯ		ТХХТ	3.000.0	Нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлсэн байна.
86.	Аймаг, бүс нутгийн онцлогт тулгуурласан аялал жуулчлалын хөтөлбөр хөгжүүлэх	1	Аймаг, бүс нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.	2013-2014	ССАЖЯ		АЗД ТББ	1.300.0 Улсын төсөв	Хөтөлбөрүүд батлагдсан байна.
		2	Горхи Тэрэлж, Хөвсгөл, Говь гурван сайхан зэрэг тусгай хамгаалалттай нутаг, түүний орчны бүсийг нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	2013-2016	БОНХЯ	ССАЖЯ	АНЗД	800.0	Хөтөлбөр хэрэгжсэн байна.
87.	Улаанбаатар хот, говийн аймгуудад үлэг гүрвэлийн цогцолбор музей, палеонтологийн лабораторийг төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор байгуулах	1	Төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан археологи, палеонтологийн болон Хүннүгийн музей, галерей, Чингис хааны ордон бүхий иргэдийн амралт чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэх парк байгуулна.	2013-2016	ССАЖЯ	БШУЯ	ШУА ХХ	44.000.0	Музей, галерей, парк байгуулагдсан байна.
		2	Өмнөговь аймгийн музейн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулна.	2013-2016	ССАЖЯ		АЗД	9.500.0 Улсын төсөв	Барилга ашиглалтад орсон байна.
		3	Шинжлэх ухааны академийн Палеонтологийн лабораторийг өргөтгөж, Археологийн лаборатори шинээр байгуулна.	2012-2016	ССАЖЯ		ШУА	3.500.0 Улсын төсөв	Лаборатори ашиглалтад орсон байна.
88.	Орон нутагт Аяллын төвүүдийг байгуулж тухайн нутгийн үзмэр, бизнес, брэнд бүтээгдэхүүнийг сурталчлах түшиц болгон ашиглах	1	Орон нутагт жишиг аяллын төвүүдийг үе шаттайгаар барьж байгуулна.	2013-2014	ССАЖЯ	БОНХЯ	АЗД	5.000.0 Улсын төсөв ХХ	Төвүүд байгуулагдсан байна.
		2	Гар урлал, өрхийн бичил үйлдвэрлэлийг дэмжинэ.	2013-2016	ХЯ	ССАЖЯ	АНЗД	500.0 ЖДҮХС	Өрхийн үйлдвэрлэл хөгжиж, нутгийн брэнд нэмэгдсэн байна.
5. Өндөр технологи, био, нано, мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжүүлэх бодлого									
89.	Их, дээд сургуулиудыг түшиглэн өндөр технологийг дэмжих сургалтын тогтолцоо бий болгож, өндөр технологийн салбарт суралцагсдын тоог нэмэгдүүлэн, гадаад орнуудтай багш солилцох ажлыг өргөжүүлэх. Энэ чиглэлд сургалт, эрдэм шинжилгээний байгууллагуудын хамтын ажиллагааг хангана	1	Био, нано, мэдээллийн технологи, электроникийн компаниуд болон их, дээд сургуулиудтай хамтран өндөр технологийн сургалт, судалгаа, үйлдвэрлэлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	2012-2016	ЭЗХЯ	БШУЯ	ИДС ХХ	4.000.0 ХХ Инновацийн сан	Хөтөлбөрүүд хэрэгжиж, үйлдвэрүүд байгуулагдсан байна.
		2	Өндөр технологи, эрдсийн боловсруулалтын технологи, сэргээгдэх эрчим хүчний 5-аас доошгүй үндэсний	2013-2015	ЭЗХЯ	БШУЯ	ИДС ХХ	5.000.0 Улсын төсөв	Үндэсний судалгааны төвүүд

			судалгааны төвийг их сургуулиудыг түшиглэн байгуулж нээлттэй хэлбэрээр ажиллуулна.						байгуулагдсан байна.
		3	Өндөр технологийн судалгаа, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг цогцоор нь хэрэгжүүлэх, өндөр технологийн гарааны компаниудыг олноор нь бойжуулан гаргах зорилготой шинжлэх ухааны парк байгуулах ажлыг судалж хэрэгжүүлнэ.	2013-2016	ЭЗХЯ	БШУЯ БХБЯ	ИДС ХХ АНЗД	10.000.0 Улсын төсөв Зээл тусламж	Паркуудын судалгаа, ТЭЗҮ хийгдэж, байгуулах ажлыг эхлүүлсэн байна.
		4	Үндэсний мэдээлэл, харилцааны технологийн судалгаа, хөгжлийн төвийг барьж байгуулна.	2013-2016	МТШХХГ	БШУЯ	ХХ	8.000.0 Улсын төсөв Гадаадын зээл	Төвийг байгуулсан байна.
		5	Экспортод суурилсан эмбэдэд /Embedded/ систем болон чипэд суурилсан системийн технологийн судалгаа хөгжлийн төв байгуулна.	2014-2017	МТШХХГ	БШУЯ	ХХ	8.000.0 Улсын төсөв	Төвийг байгуулсан байна.
		6	Чип дизайны үйлдвэр байгуулна.	2012-2016	МТШХХГ	ЭЗХЯ БШУЯ		7.500.0 Улсын төсөв	Үйлдвэрийг байгуулсан байна.
		7	Дотоодын программ хангамжийн зах зээлийг хангах, олон улсын стандартад нийцсэн чанарын менежментийг нэвтрүүлнэ.	2014-2015	МТШХХГ		ХХ	15.000.0 Улсын төсөв	Менежментийг нэвтрүүлсэн байна.
		8	Яриаг таньж кирилл бичгийн текстийн файл болгох, кирилл бичгийн текстийг яриа болгох "ухаалаг программ хангамж"-ийг боловсруулна.	2013-2015	МТШХХГ	БШУЯ	ХХ	8.000.0 Улсын төсөв	Программ хангамжийг боловсруулан нэвтрүүлсэн байна.
90.	Шинжлэх ухааны бүтээлийг дэмжих, чанарыг сайжруулах, зах зээлд нэвтрүүлэх зорилгоор Шинжлэх ухаан, технологийн сангаас олгох хөрөнгийг их, дээд сургууль, шинжлэх ухааны байгууллагуудын дунд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах замаар хуваарилдаг болох	1	Шинжлэх ухаан, технологийн сангаас ногоон хөгжил, байгалийн нөөц, экосистемийн судалгаа шинжилгээний ажилд зарцуулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, ногоон технологийг нэвтрүүлнэ.	2013-2016	БОНХЯ	БШУЯ	ШУА	1.500.0 ШУТС	Ногоон технологийн судалгааны хөрөнгө оруулалт нэмэгдсэн байна.
		2	Шинжлэх ухаан, технологийн сангаас санхүүжүүлэх эрдэм шинжилгээний ажлыг сонгон шалгаруулахдаа тухайн салбарын тэргүүлэх эрдэмтэн, судлаачдыг өргөнөөр оролцуулж, хэлэлцүүлэн дүгнэлт гаргах үйл ажиллагааг боловсронгуй болгоно.	2012-2016	БШУЯ	БХБЯ ЭЗХЯ		4.800.0 Улсын төсөв	Төслүүд хэрэгжсэн байна.
91.	Мэдээлэл холбоо, нано, биотехнологийн чиглэлээр гадаад, дотоодын их, дээд сургуулиудтай хамтран ажиллах үйл ажиллагааг хөгжүүлж, эдгээр мэргэжлээр 300-гаас доошгүй оюутныг дэлхийн шилдэг сургуулиудад оюутан солилцоогоор сургах	1	Мэдээллийн технологи, нано, био технологийн мэргэжилтэн, мэргэжлийн багш нарыг өндөр хөгжилтэй оронд мэргэжил дээшлүүлэх, давтан сургах, орон нутгийг тухайн чиглэлийн мэргэжлийн боловсон хүчнээр хангах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлнэ.	2013-2016	БШУЯ	МТШХХГ	ХХ	20.000.0 Улсын төсөв Гадаадын зээл	Өндөр хөгжилтэй оронд бэлтгэгдсэн мэргэжилтэн, мэргэжлийн багш нарын тоо нэмэгдсэн байна.

92.	Төлбөр тооцоо, бүртгэлийн бүх үйл ажиллагааг цаг хугацаа, орон зайнаас үл хамааран хийж гүйцэтгэх орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх	1	Аж ахуйн нэгж, байгууллагын улирал, жилийн санхүүгийн тайланг электрон хэлбэрээр хүлээж авах нөхцөлийг бүрдүүлж, санхүүгийн тайланг тушаахад үүсч байгаа хүндрэлийг арилгана: а) И-баланс веб сайтын программ хангамжийг шинэчилнэ. б) санхүүгийн тайланг хүлээж авах хугацаа болон аргатай холбоотой хууль тогтоомжид өөрчлөлт оруулах төсөл боловсруулна.	2013-2014	СЯ	ХЗЯ	ДБ-ны төсөл		Электрон тайлангийн тогтолцоо бүрдсэн байна.
		2	Банк, бизнесийн байгууллагын төлбөр тооцоонд интернэт, утасгүй холбооны технологийг ашиглах эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.	2013-2015	МТШХХГ	ХЗЯ СЯ Монголбанк	XX	1.000.0 Улсын төсөв	Эрх зүйн орчныг боловсронгуй болгосон байна.
		3	Кадастрын бүртгэлийн системийг бүрэн автоматжуулж, харилцагчдад үзүүлэх үйлчилгээг чанартай, шуурхай болгоно.	2014-2015	МТШХХГ	БХБЯ ХЗЯ	XX	1.000.0 Улсын төсөв	Үйлчилгээ шуурхай, чанартай болсон байна.

6. Импортыг орлох экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих бодлого

93.	Импортоор оруулдаг хүнсний бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэдэг болж, төмс, хүнсний ногоо, сүү, өндөгний хэрэгцээг дотооддоо хангадаг болох	1	Таримал ургамлын генетик нөөцийг ашиглах, хамгаалах, төмс, хүнсний ногооны тариаланг даатгалд хамруулах асуудлыг судалж, эрх зүйн орчинг бүрдүүлнэ.	2013-2016	ҮХААЯ			5.0 Улсын төсөв	Эрх зүйн орчин бүрдсэн байна.
		2	Төмс, хүнсний ногооны үр үржүүлэг, сорт, сорилт, үйлдвэрлэлийн тогтолцоог шинэчлэн зохион байгуулна.	2013-2014	ҮХААЯ			6.200.0 Улсын төсөв	4 бүсэд үр үржүүлэг, сорт сорилтын төв байгуулсан байна.
		3	Ганд тэсвэртэй, ургац өндөртэй элит болон супер элит буудайн 3 сорт, усалгаанд эрчимжсэн 2 сортыг үйлдвэрлэлд нэвтрүүлнэ. Элит болон супер элит үрийг импортоор авч үржүүлнэ.	2013-2016	ҮХААЯ			8.000.0 Улсын төсөв	Стандартад нийцсэн үрээр 100 хувь тариалалт хийдэг болсон байна.
		4	Тэжээл, тос, техникийн таримлын тариалалтын техник, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлнэ.	2013-2016	ҮХААЯ			20.000.0 Улсын төсөв	Хангамж нэмэгдүүлсэн байна.
		5	Тэг, цомхотгосон технологиор боловсруулсан уриншийн эзлэх хувийг нэмэгдүүлэх, эрдэс бордооны үйлдвэр байгуулна.	2013-2016	ҮХААЯ			45.000.0 Улсын төсөв	Үйлдвэр байгуулагдсан байна.
		6	Ойн зурвас байгуулах, хашаажуулах замаар тариалангийн талбайн хөрсийг элэгдэл, эвдрэлээс хамгаалж, үржил	2012-2016	ҮХААЯ	БОНХЯ		8.000.0	20 000-аас доошгүй га-д ойн зурвас

			шимийг сайжруулна.						байгуулсан байна.
		7	Төмсний үрийг шинэчлэх ажлыг эрчимжүүлж 500.0 мянган ширхэг бичил булцуу үйлдвэрлэнэ.	2013-2016	ҮХААЯ			10.500.0 Улсын төсөв	Супер элит, элит үрээр дотоодын хэрэгцээг 100 хувь хангасан байна.
		8	Хүнсний ногооны тариалан бүхий аймгуудад төмс, хүнсний ногоо угаах, ангилах, савлах, дахин боловсруулах, төмсний гурил, шарсан төмс үйлдвэрлэх, хөргөөж хөлдөөн савлах үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	2013-2016	ҮХААЯ	ЭЗХЯ		15.000.0 Улсын төсөв	10-аас доошгүй үйлдвэр, цех байгуулагдсан байна.
		9	Хүнсний ногооны өрхийн бичил үйлдвэрлэл, босоо ба хөдөлгөөнт тариалан хөгжүүлэх "СТ-100" Үндэсний сүлжээ байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	2013-2016	ҮХААЯ			2.000.0 Улсын төсөв	Суурин газрын хүн амын 20 хувь нь гэртээ ногоо тарьдаг болсон байна.
		10	Чацаргана болон жимс жимсгэний сорт судалгааны талбарыг бүсчлэн байгуулж, нийт 7 төрлийн жимс жимсгэний ургамлын 19 сортыг сонгон тариалах агротехнологийг үйлдвэрлэлд нэвтрүүлнэ.	2013-2016	ҮХААЯ			4.000.0 Улсын төсөв	19 сортыг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байна.
		11	Чацаргана, алим, гүзээлгэнэ, чавга, интоор үржүүлгийн загвар аж ахуй байгуулахад зээл олгож, импортоор суулгац нийлүүлэх замаар тариалалт, үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	2013-2016	ҮХААЯ			20.000.0 Улсын төсөв	Тариалалтыг 16.0 мянган га, ургацыг 33.5 мянган тоннд хүргэсэн байна.
		12	Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх ажлыг эхлүүлнэ.	2013-2016	ҮХААЯ			15.000.0 Улсын төсөв	Тогтолцооны эхлэл тавигдсан байна.
		13	Хөрс боловсруулах, ургац хураах, ургамал хамгаалах орчин үеийн техник, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлнэ.	2013-2016	ҮХААЯ			1.200.0 Улсын төсөв	Механикжилтын түвшин 50 хувьд хүрсэн байна.
		14	Жимсийг огцом хөлдөөн хадгалах зөөврийн хөргөлттэй агуулахын хангамжийг сайжруулж, бүс нутгуудыг хамарсан хадгалалтын агуулахын сүлжээ байгуулна.	2013-2016	ҮХААЯ			3.000.0 Улсын төсөв	Сүлжээ байгуулагдсан байна.
		15	Сүү бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор сүү хөргөх, хадгалах, тээвэрлэх зориулалт бүхий иж бүрэн хөргөлтийн төв байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	2013-2014	ҮХААЯ		ХХ	5.000.0 Улсын төсөв	50-иас доошгүй хөргөлтийн төв байгуулагдсан байна.
		16	Дотооддоо үйлдвэрлэх бололцоотой шингэн сүү, тараг, цөцгийн тос, зайрмаг, бяслаг зэрэг бүтээгдэхүүний импортын гаалийн албан татварын хувь хэмжээг улирлын ялгаатайгаар нэмэгдүүлнэ.	2013-2014	ҮХААЯ	СЯ		1.000.0	Татварыг 10-15 хувиар нэмэгдүүлж, уурагт бүтээгдэхүүний 10 үйлдвэр

								байгуулсан байна.
		17	Нийслэл болон томоохон хот суурингийн ойролцоо 300-гаас доошгүй үнээтэй сүүний чиглэлийн үхрийн цогцолбор, аймгийн төвүүдийн ойролцоо 50-иас доошгүй үнээтэй аж ахуйг шинээр байгуулна.	2013-2016	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ	100.000.0	Цогцолбор, аж ахуй байгуулагдсан байна.
		18	5 аймагт сүүний чиглэлийн ямаа үржүүлэх аж ахуй байгуулж, хүүхдийн сүүн тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	2013-2016	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ	50.000.0 Улсын төсөв	Тус бүр 200 ямаа бүхий 5 аж ахуй бий болсон байна.
		19	Хоногт 1 тонноос доошгүй сүү боловсруулах үйлдвэр байгуулж, хоршоо, малчны бүлэг, өрхийн үйлдвэрлэлээр цөцгийн тос үйлдвэрлэх зориулалт бүхий багц тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг нийлүүлж, үйлдвэрлэл эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлнэ.	2013-2014	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ	3.500.0 Улсын төсөв	5-аас доошгүй үйлдвэр байгуулагдаж, цөцгийн тосны хэрэглээний 20 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангадаг болсон байна.
		20	Хот суурингийн орчимд 100.0 мянгаас дээш өндөглөгчтэй тахианы цогцолбор аж ахуй 3, аймгийн төвүүдэд 5.0 мянгаас дээш өндөглөгчтэй эрчимжсэн аж ахуй 8-ыг тус тус шинээр байгуулж, өндөгний хангамжийг нэмэгдүүлнэ.	2013-2015	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ	АНЗД 20.0	Хүн амын өндөгний хэрэгцээг дотоодоос хангадаг болсон байна.
		21	Өндгийг угаах, хатаах, ариутгах, жинлэх зэрэг үйлдэл хийх өндөг боловсруулах үйлдвэр, өдөрт 1000-3000 тахиа нядлах хүчин чадалтай цех байгуулна.	2014-2016	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ	1.700.0 Улсын төсөв	Нийт өндөгний 70 хувийг боловсруулан нийлүүлж, тахианы махны нийлүүлэлтийг нэмэгдүүлсэн байна.
94.	Тариаланг дэмжих сангийн үйл ажиллагааг хувийн хэвшлийн оролцоо бүхий корпораци болгон зохион байгуулах	1	Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн бүтэц үйл ажиллагааг төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн харилцан түншлэлийн оролцоотой корпораци болгон зохион байгуулах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.	2013	ҮХААЯ			Эрх зүйн орчин бүрдсэн байна.
		2	Тариалангийн баруун, зүүн, хангайн бүсэд Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн салбарыг байгуулна.	2013-2015	ҮХААЯ		24.300.0 Улсын төсөв	Салбарууд байгуулагдсан байна.
95.	Баруун бүсэд газар тариалан эрхлэлтийг хөгжүүлж, бүсийн гурилын хэрэгцээгээ хангадаг болох	1	Бүс нутгийн онцлогт тохирсон үр үржүүлэх, шинэчлэх ажлыг эрчимжүүлж, үрийн чанар хангамжийг сайжруулна.	2013-2016	ҮХААЯ		3.000.0 Улсын төсөв	Үрийн чанар, хангамж сайжирсан байна.
		2	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар усны хайгуул судалгаа, зураг төсөл хийж,	2013-2014	ҮХААЯ		11.100.0 Улсын төсөв	Бүсийн дотоодын үйлдвэрлэлийн

			услалтын системийг сэргээн засварлахад дэмжлэг үзүүлнэ.						гурилын хангамж нэмэгдсэн байна.
96.	Хүнсний ногооны тариалалт, хураалтыг механикжуулж, агуулахын аж ахуйг хөгжүүлэх ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх, хүнсний ногооны дотоодын хэрэгцээг бүрэн хангах	1	Хүнсний ногооны үр үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	2013-2016	ҮХААЯ			8.000.0 Улсын төсөв	10-аас доошгүй шинэ сортыг дотооддоо үйлдвэрлэсэн байна.
		2	Дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлэн дотоодын үйлдвэрлэлийг дэмжинэ.	2012-2016	ҮХААЯ			34.000.0 Улсын төсөв	Техник хангамжийг 60 хувьд хүргэж, 5.0 мянган га талбайг усжуулсан байна.
		3	Био бордооны үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	2013-2016	ҮХААЯ			8.000.0 Улсын төсөв	Дотоодын хэрэгцээний 40 хувийг хангадаг болсон байна.
